



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ЗАРИМ ОРНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ СУДАЛГАА

2022

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Захиалагч:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Удирдсан:

С.Сүхбаатар Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

А.Намуунаа	Эрдэм шинжилгээний ажилтан
З.Мөнгөлжин	Эрдэм шинжилгээний ажилтан /Япон/
Э.Анударь	Эрдэм шинжилгээний ажилтан /БНСУ/

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	3
I. УДИРТГАЛ	4
II. НЭРШИЛ, НЭР ТОМЬЁО.....	5
III. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТОГТОЛЦОО	6
IV. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ	23
V. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА.....	33
VI. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА.....	56
VII. ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛЭЭС ЗАЙЛСХИЙХ ҮЙЛДЭЛ БОЛОН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА ..	64
VIII. ДҮГНЭЛТ	65
IX. НОМ ЗҮЙ.....	67

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БНСУ-	Бүгд Найрамдах Солонгос Улс
ШтХ-	Шүүхийн тухай хууль
ШШГГ-	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ХБНГУ-	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ИХШШГТХ-	Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ИШГАТХ-	Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хууль

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, захиргаа, эрүү, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь зохицуулсан байна. Харин Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.8 дугаар зүйлд Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулахаар заажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1-д “...иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах” гэж заасны дагуу иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар чиглэл болгосон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл боловсруулах үйл явцтай холбогдуулан хөгжингүй гаднын улсын иргэн, захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх тогтолцоо, нэршил, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, эрх олгодог болон хяналт тавих субъект, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, гуравдагч этгээдийн зүгээс зайлсхийж байгаа үйлдэлд хүлээлгэх хариуцлага зэрэг зохицуулалтын талаар судалгаа хийлгэх захиалагчийн хүсэлтийн дагуу энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааг гүйцэтгэхийн тулд Азийн орнуудаас Монгол улстай хамтын ажиллагааны цар хүрээ өргөн, эрх зүйн хөгжил өндөртэй Япон, БНСУ, харин Европын орнуудаас ХБНГУ, Испани, Швед улсуудыг сонгож захиргаа болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбогдох хууль, тогтоомж, судалгааны тайлан гэх мэтийг судалж, зарим онцлог зохицуулалтыг түүвэрлэн судалж дүгнэнэ.

II. НЭРШИЛ, НЭР ТОМЬЁО

Улс орнуудын түүхэн уламжлал, хэл, соёлын ялгаанаас хамааран шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон уг ажиллагааны оролцогчдын нэршил харилцан адилгүй нэрлэгдэж байгаа хэдий ч нэр томьёоны хувьд ижил агуулгатай байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож буй хариуцагчийг нэрлэхэд төлбөр төлөгч (анг. debtor- өртэй хүн) гэх нэр томьёог ашигладаг боловч олон улсад бодит байдал дээр "үйлчлүүлэгч" гэж нэрлэх нь түгээмэл болсон. Төлбөр төлөгчдийг "үйлчлүүлэгч" гэж нэрлэх логик нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нийт харилцааны ердөө нэг хэсэг тул төлбөр төлөгчийг "үйлчлүүлэгч" гэж нэрлэх нь илүү өргөн хүрээний харилцаанд анхаарал хандуулж, төлбөр төлөгчид хүндэтгэлтэй хандах шаардлагатайг онцолдог.

Төлбөр авагч нь төлбөр авагч, шийдвэр гүйцэтгэх байгууллага, төлбөр төлөгч гэсэн гурван талт харилцаанд шийдвэр гүйцэтгэх байгууллагын "харилцагч" юм. Гэвч "харилцагч" болон "үйлчлүүлэгч" гэсэн нэр томьёог дурдах нь мөн учир дутагдалтай, шүүмжлэл дагуулдаг тул "төлбөр авагч" болон "төлбөр төлөгч" гэсэн нэр томьёог ашигладаг хэмээн тэмдэглэжээ.¹

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч- "Шүүхийн үүрэг гүйцэтгэгч" (анг. bailiff) гэдэг үгийг англи хэл рүү орчуулахдаа шийдвэр гүйцэтгэх үүрэг хүлээсэн хүн буюу хүмүүсийн нэг гэж орчуулагддаг.²

Оксфордын англи хэлний тайлбар толь бичигт 'шийдвэр гүйцэтгэгч' гэсэн нэр томьёо нь түүхэн явцад янз бүрээр тодорхойлогдож байжээ.

1. Тодорхой дүүрэгт төрийн захиргааны эрх мэдлээр хариуцлага хүлээсэн нэгэн. а. Англид өмнө нь хааны офицеруудад, тэр дундаа хааны нэр дэвшүүлсэн шериф, хотын захирагч гэх мэт, зуутын ахлах офицеруудыг хэлдэг байсан; ... 2. Шерифийн дэргэдэх бичиг баримтыг гүйцэтгэгч, захиран зарцуулдаг, баривчилдаг хууль сахиулах ажилтан; ... 3. Байшингийн эзний түрээсийг хураадаг төлөөлөгч гэх мэт; газар эзэмшигчийн хөрөнгийг зохицуулдаг нярав; гэх зэргээр тодорхойлогджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид нь дундад зууны Англид эрх мэдэлтэн, язгууртнууд байсан бөгөөд одоо ч зарим тохиолдолд хэвээр хэрэглэж байгаа тохиолдол байна. Гэхдээ нэр томьёо нь албан ёсны ур чадвар, гүйцэтгэх үүрэг хариуцлагын хувьд хязгаарлагдмал

¹ Wendy Kennett, Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge, 2021, page 12

² Мөн тэнд, 13 дахь тал

хувь хүнд хамаарах болсноороо ялгаатай. Тэдний үүрэг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шууд чиглүүлэх бус харин хариуцагчтай уулзах үед шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэдэг. Аль ч улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид нэр хүндтэй, өндөр албан тушаалтан байх нь ховор боловч "шийдвэр гүйцэтгэгч" гэдэг нь шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэшил, статус, чадамжийн цар хүрээг илэрхийлж чаддаггүй шийдвэр гүйцэтгэх ажиллагааны механизмын нэг хэсэг болж ажилладаг хүнийг тодорхойлоход ашигладаг.³

III. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТОГТОЛЦОО

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр авагч шүүхийн шийдвэрээр тогтоосон эрхээ эдлэх боломжтой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шат юм. Төлбөр төлөгч нь шүүхээс тогтоосон үүргээ сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг.⁴ Иргэдийн шүүхэд итгэх итгэлийн хамгийн гол нэг нөхцөл нь шүүхийн шийдвэр биелэгддэг байх явдал.

Улс бүрт шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоо харилцан адилгүй байдаг. Шүүхийн шийдвэр бодитой биелснээр иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол хамгаалагдах боломж бүрдэх учиртай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг санхүүжилтийнх нь хэлбэрээр төрийн, холимог, хувийн гэж гурав хувааж үздэг байна. Харин шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог субъектээр нь дараах гурван төрөлд хуваах боломжтой:

- *Шүүхийн тогтолцоо*: шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг шүүхийн "шийдвэр гүйцэтгэгч" хэрэгжүүлдэг бөгөөд гүйцэтгэх засаглалаас хараат бусаар шүүхийн хяналтанд үйл ажиллагаа явуулна. (Австри, Словени, БНСУ)
- *Төрийн албан хаагчийн тогтолцоо*: шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг "төрийн албан хаагч" шүүхээс хараат бусаар, тухайлбал Хууль зүйн ямаар дамжуулан хэрэгжүүлнэ. (ХБНГУ, Швед, Финланд, Малта)
- *Хууль хэрэгжүүлэх хувийн байгууллагын тогтолцоо*: шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүхээс хараат бусаар зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулна. (Польш, Белги, Булгар, Чех, Эстони, Франц, Грек, Унгар, Латви, Люксембург, Нидерланд, Португал, Романиа, Шотланд, Словак, Словени)

³ Мөн тэнд.

⁴ The Enforcement of a Title in Germany, https://www.mmrecht.com/claim_collection/enforcement_en.php (Сүүлд үзсэн: 2022.05.27)

Шүүхийн болон төрийн албан хаагчийн тогтолцоог шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн тогтолцоо гэж авч үздэг бол хувийн байгууллагын тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хувийн тогтолцоонд хамаарна. Дан шүүхийн эсхүл төрийн албан хаагчийн тогтолцооноос гадна хувийн аж ахуйн нэгжүүд шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг холимог тогтолцоотой улс орнууд бий. Жишээ нь, Франц, Болгар, Казахстан улсад хувийн байгууллагаас гадна төрийн шийдвэр гүйцэтгэгч байдаг байна.⁵

Дээрхтэй төстэйгөөр Профессор Вэнди Кэнэттийн номд өөр өөр эрх зүйн тогтолцоо бүрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны арга барил ялгаатай байдаг хэдий ч гурван институцийн “загвар”-аар бүлэглэж болно гэжээ.⁶ Үүнд:

- *Захиргааны загвар*: Энэ загвар нь нийтийн болон хувийн эрх зүйн санхүүгийн үүргийн хэрэгжилтийг төрийн удирдлагын нэг хэсэг болох гүйцэтгэх байгууллага хариуцдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид төрийн албан хаагчийн статустай байдаг. Швед, Финланд улсууд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн энэ загварын цорын ганц төлөөлөгч юм.
- *Шүүхийн ажилтны загвар*: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны загвар нь улсуудад хамгийн өргөн хэрэглэгддэг загвар бөгөөд гарал үүсэл нь 14-р зууны Францаас улбаатай гэж үздэг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэх чиглэлээр мэргэшсэн ажилтан гүйцэтгэж, үзүүлсэн үйлчилгээгээрээ орлого олдог. Зарим улс оронд Шүүхийн ажилтнууд иргэний болон арилжааны асуудлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөвхөн хариуцдаг. Бусад тохиолдолд тэд нийтийн эрх зүйн өрийг барагдуулах үүрэгтэй боловч өөр нэмэлт ажлуудыг мөн гүйцэтгэдэг.
- *Шүүх төвтэй загвар*: Шүүх шүүхийн шийдвэрийн биелэлтийг хүртэл хариуцна (мөн бусад шийдвэр гүйцэтгэх эрхийг хэрэгжүүлнэ). Шүүх тодорхой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг (бараа хураан авах гэх мэт) эхлүүлэхийн тулд төлбөр авагчийн гаргасан өргөдлийн үндсэн дээр арга хэмжээ авдаг.

Европын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай ном зохиолд тэмдэглэснээр "шийдвэр гүйцэтгэх эрх" гэдэг нь үүргийг биелүүлэхийн тулд төрийн эрх мэдлийг ашиглах,

⁵ Государственная и частная системы принудительного исполнения: сравнительный анализ и лучшие практики: сборник материалов 9-й Международной научно-практической конференции, 10-13 октября 2018 г., г. Сочи, Краснодарский край/ отв. Ред. Д.В.Аристов, В.А.Гуреев. М., 2019. стр.30-31

⁶ Wendy Kennett, Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge, 2021, page 9

тэр дундаа шаардлагатай бол хүч хэрэглэхийг зөвтгөх шүүхийн шийдвэр, захирамж болон бусад баримт бичгүүдийн ерөнхий нэр томьёо юм. Тиймээс иргэний эрх зүйн хүрээнд шийдвэр гүйцэтгэх эрхийн баримт бичигт иргэний болон арилжааны хэргийн шүүхийн шийдвэр, нотариатаар гэрчлүүлсэн (жинхэнэ) баримт бичиг орно. Эрх зүйн тогтолцооноос хамааран шүүхээс бусад байгууллагаас олгосон чек, вексель, төлбөрийн даалгавар, арбитрын шийдвэр болон бусад хэрэглүүр нь мөн гүйцэтгэх эрхийн бичиг байж болдог.

Төлбөр авагчид болон тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зарим тогтолцоонд төлбөр авагч бусдаасаа давуу эрх мэдлийг олгодог (жишээ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрлийг сонгох). Энэ нь их хэмжээний мөнгөн эрсдэлд орсон болон төлбөр авагч төлбөр төлөгчийн талаар маш их мэдээлэлтэй байгаа эсвэл бусад шалтгаанаар шийдвэр гүйцэтгэх тодорхой стратеги хэрэгжүүлэхийг хүсч байгаа тохиолдолд хэрэгцээтэй байдаг. Ихэвчлэн шүүх төвтэй эсвэл холимог загвартай улс орнуудад шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр авагчийн гаргасан өргөдлийн дагуу явагддаг бөгөөд ингэснээр тэд уг үйл явцыг тодорхой хэмжээгээр удирддаг ч хуульд мөн тодорхой хязгаарлалтууд байдаг.

Эдгээр загвар, бүтцээс үл хамааран шүүхийн шийдвэр гүйцэтгэх арга хэмжээ нь зарчмын хувьд ижил төстэй бөгөөд зөвхөн тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжууд байдаг. Үүнд:

- хөрөнгө хураах, худалдах (биет хөдлөх хөрөнгө);
- гуравдагч этгээдийн хөрөнгийг хураах (ихэвчлэн банкны данс, орлого эсвэл цалин хөлс, гэхдээ аливаа нэхэмжлэлд хамаарах боломжтой);
- үл хөдлөх эд хөрөнгийг хураах (өр барагдуулах мөнгө олох зорилгоор худалдах, захиран зарцуулах, жишээлбэл, түрээсийн орлого эсвэл бүтээгдэхүүн борлуулах замаар);
- шийдвэр гүйцэтгэх эрхийг хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэх, ингэснээр бүртгэлтэй эд хөрөнгийг зээлдүүлэгчид төлбөр төлөхгүйгээр худалдах боломжгүй;
- хорих болон жолооны үнэмлэх, ан агнах зөвшөөрлийг түдгэлзүүлэх зэрэг бусад шийтгэл.

Дээрхээс гадна үндэсний эрх зүйн онцлогоос хамаарах өөр хувилбарууд байдаг. Орчин үед иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэчлэх үйл явц нь төлбөр төлөгчийн хөрөнгө, орлогод гарсан өөрчлөлтөөс ихээхэн шалтгаалж байна. Биет хөрөнгөөс биет бус хөрөнгө рүү шилжих, орлогын төрлийг төрөлжүүлэх нь эд хөрөнгө,

газрыг хураахад чиглэсэн арга хэмжээ авах уламжлалт арга барилыг хангалтгүй болгож байгаа нь шийдвэр гүйцэтгэх практикийн гол шинж чанар болсон.⁷

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн тогтолцоонд шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрөөс санхүүжилттэй, иргэний хувийн нууцлалтай мэдээллийг авах зэргээр хуулиар олгогдсон эрх мэдэлтэй байх ёстой. Төрийн тогтолцоо нь дараах онцлогтой. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн цалин урамшууллыг төсвөөс олгодог тул орлого тогтвортой байхаас гадна шүүхийн шийдвэрээр гаргуулах төлбөрийн хэмжээнээс хамаарахгүйгээр шийдвэрийг гүйцэтгэх төрийн баталгаа байдаг.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь өндөр үнийн дүн бүхий төлбөр гаргуулах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эсэхээс үл хамааран бүхий л шүүхийн шийдвэрийг биелүүлнэ.
- Нэгдмэл удирдлагатай байх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, шийдвэр гүйцэтгэгчид хуулийг нэг мөр хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

Харин шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх хувийн тогтолцоо нь тухайн шийдвэрийг биелүүлэх бүхий л арга замыг эрэлхийлэн зохих хөрөнгийг гаргуулдаг. Үйлчлүүлэгч нь шүүхийн шийдвэрийг хамгийн богино хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлж чадах байгууллагыг сонгох боломжтой юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн болон хувийн тогтолцоог гурван талаас нь харьцуулан үзвэл:

Төрийн талаас: иргэдийн төр болон хууль хэрэгжүүлэх байгууллагыг хүлээн зөвшөөрөх байдлыг харгалзан үзэх хэрэгтэй. Хувийн тогтолцоог иргэд хүлээн зөвшөөрч, шаардлагыг нь биелүүлэхэд тодорхой хэмжээнд бэрхшээлтэй байдаг. Учир нь төрийн тогтолцоотой улс оронд ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь бусад төрийн байгууллагын, тухайлбал цагдаагийн байгууллагын туслалцаа, оролцоотойгоор үйл ажиллагаагаа явуулах тохиолдол элбэг байна.

Мэргэжлийн үйл ажиллагаа талаас: шүүхийн шийдвэр гүйцэтгэгч албан хаагчийн хувьд төрийн тогтолцоо хамгийн тааламжтай байдаг. Учир нь шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байр, цалин орлого илүү баталгаатай, тогтвортой бөгөөд тодорхой байдаг. Харин хувийн шийдвэр гүйцэтгэгч нь ажилчдадаа олгох цалин хөлс, түрээс, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэхээс гадна хувийн хариуцлага хүлээж, төлбөрийн чадваргүй болох эрсдэл өндөр байдаг.

⁷ Wendy Kennett, Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge, 2021, page 11

Зах зээлийн талаас: шийдвэрийг гүйцэтгэж буй этгээд ашгийн төлөө байдаг учраас нэг талаасаа төлбөр төлөгчид бүхий л арга хэмжээг авч ажиллана. Нөгөө талаасаа, шударга, үр дүнтэй шийдвэр гүйцэтгэл нь дан ганц ашиг орлого дээр суурилах учир эрсдэлтэй тал бий.⁸

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн, хувийн эсхүл холимог тогтолцоог сонгох эсэх нь эрх зүйн тогтолцооноос бус тухайн улсын эдийн засаг, улс төр, захиргааны болон бусад хүчин зүйлээс шалтгаалдаг. Иймд нэг улсад үр дүнтэй хэрэгжиж буй тогтолцоог өөр нэг улс авч хэрэгжүүлснээр үр дүнтэй байна гэсэн үг биш юм.⁹

Цахим мэдээлэл хүртээмжтэй эрин үед олон улс орнууд өр төлбөртэй холбоотой мэдээлэлд хандах боломжтой системийг бий болгосон. Үүнд татварын алба, нийгмийн даатгалын байгууллага, банк, тээврийн хэрэгслийн зөвшөөрөл олгох байгууллага, нутгийн зөвлөлийн мэдээлэл, үнэт цаас болон бусад бүртгэлтэй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд хялбар хандах боломжтой.

Мэдээллийн өөр нэг эх сурвалж бол төлбөр төлөгчөөс авсан хөрөнгийн тайлан юм. Төлбөр төлөгчид энэ мэдээллийг эрх бүхий шийдвэр гүйцэтгэх байгууллагад өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түгээмэл арга нь хөрөнгийг хураан авах билээ. Төлбөр төлөгчөөс төлбөр авах боломжгүй тохиолдолд эд хөрөнгийг нь битүүмжлэх нь шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын үндсэн чиг үүргийн нэг юм. Үл хөдлөх эд хөрөнгийг хураах (ялангуяа ипотекийн зээлийн хэрэг) нь төлбөр авагчийн эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байж болох бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэх байгууллагууд ч процессын явцад бичиг баримтын үйлчилгээ үзүүлэхээс авхуулан шаардлагатай тохиолдолд эд хөрөнгөд халдах замаар оролцдог. Энэ ажиллагааг гүйцэтгэхэд гуравдагч этгээдээс шийдвэр гүйцэтгэх байгууллагад туслалцаа үзүүлэхийг шаардаж болно.

Хөрөнгийг битүүмжлэн хураасны дараа хөрөнгийн үнийг бодитой болгох журмыг эхлүүлнэ. Хөдлөх эд хөрөнгийг хураан авах үүрэгтэй байгууллага нь ихэвчлэн худалдах ажиллагааг хариуцдаг ч дуудлага худалдаагаар мэргэшсэн мэргэжилтнүүдийг мөн ажиллуулж болно. Үл хөдлөх эд хөрөнгө эрх ашгийн хувьд илүү төвөгтэй байдаг тул

⁸ Государственная и частная системы принудительного исполнения: сравнительный анализ и лучшие практики: сборник материалов 9-й Международной научно-практической конференции, 10-13 октября 2018 г., г. Сочи, Краснодарский край/ отв. Ред. Д.В.Аристов, В.А.Гуреев. М., 2019. стр.32

⁹ Мөн тэнд, 25 дахь тал

шүүхийн оролцоо их байдаг. Учир нь цэвэр өмчийн эрхээс гадна хариуцагчийн үндсэн эрх, өрхийн бусад гишүүдийн эрх, ашиг сонирхол хөндөгддөг. Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн аль алиныг нь худалдахад цахим дуудлага худалдаа явуулах явдал улам бүр нэмэгдэж байна. Эдгээрийг ихэвчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор бүтээсэн тусгай дижитал платформоор дамжуулан зохион байгуулдаг боловч зарим улс оронд арилжааны сайтуудыг ашиглаж байна.

Нэгээс дээш нэхэмжлэлтэй төлбөр төлөгчийн тодорхой хөрөнгийг хураан авах үед аль төлбөр авагчийн шаардлага нэн тэргүүнд хангагдах ёстой вэ гэдгээс хамааран шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Хэрэв хураан авсан хөрөнгө нь нэгээс илүү өрийг төлөхүйц өндөр үнэтэй биш бол дараагийн төлбөр авагчид хураан авах өөр хөрөнгө хураан авч өгдөг. Зарим улс орнууд бүх төлбөр авагчидтай адил тэгш харьцдаг, эсхүл төлбөр авагчдад давуу эрх олгох тухай өөр зохицуулалтыг хийсэн байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн ажилтан гүйцэтгэдэг улсуудад тухайн албан тушаалтан хөрөнгийг хураан авахдаа гуравдагч этгээдийн бараа борлуулснаас олсон орлого, төлбөрийг хуваах асуудлыг мөн шийдвэрлэдэг. Шүүхийн ажилтан нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой борлуулалт, удирдлагын орлогыг хуваарилах бүрэн эрхтэй байж болох ч шүүх, нотариатын оролцоо шаардагддаг.¹⁰

(1) Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо

Монгол Улсын хувьд 1921 оноос хойш тухайн үед анхны байгуулагдаж байсан “Гяндан хороо”-ны үйл ажиллагааг зохицуулах, гяндангийн дэргэд түр мөрдөх заавар, Их гяндангийн дүрэм, 1931 оны Аливаа хэрэгтнийг ялтанг засан сайжруулах тухай бие даасан анхны хуулиас эхлээд 1966, 1981 оны Засан хүмүүжүүлэх хуулиуд, 1993 онд Хорих байгууллага, хорих ял эдлүүлэх ажиллагааны тухай хууль, 1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль, 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд мөрдөгдөж байжээ.¹¹

Одоогийн байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулах ба бие даасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүх засаглалын томоохон бүрэлдэхүүн хэсэг юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үүсэн байгуулагдаж, хөгжих явцдаа ял эдлүүлэх байгууллага буюу

¹⁰ Wendy Kennett, Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge, 2021, page 30-33

¹¹ “Ц.Очгэрэл: Шүүхийн шийдвэр хуулийн адил хэлбэрэлтгүй хэрэгжиж байх ёстой”, 2021.05.31 <https://news.mn/r/2436640/>

үндсэндээ эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэгтэй байсан бөгөөд тогтолцооны хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрддэг байв.¹²

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу эрүүгийн хэргээс гадна иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхээр заасан нь Монгол Улс шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн тогтолцоотойг илэрхийлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт зааснаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байдаг. Тухайн шийдвэрүүд, тэдгээрт үндэслэн олгогдсон гүйцэтгэх хуудсыг нэгтгэн “Гүйцэтгэх баримт бичиг” гэх бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглодог.

Гүйцэтгэх баримт бичигт гүйцэтгэх баримт бичгийг олгосон шүүх, бусад байгууллагын нэр; шийдвэр гаргасан огноо, дугаар; тухайн гүйцэтгэх баримт бичгийг олгосон үндэслэл; төлбөр авагч болон төлбөр төлөгчийн бүрэн мэдээлэл; төлбөр авагчид олговол зохих төлбөрийн төрөл, хэмжээ; шүүх, бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн хүчин төгөлдөр болсон хугацаа зэргийг заасан байна. Уг шаардлагыг хангаагүй гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авахгүй буцаадаг.

Ахлах гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг шаардлага хангасан гэж үзвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилж шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсдэг байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хугацааны тухайд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 06.00 цагаас 22.00 цагийн хооронд явуулах ба тодорхой цагийг шийдвэр гүйцэтгэгч өөрөө тогтоодог. Ажлын бус өдөр, эсхүл 22.00 цагаас 06.00 цагийн хооронд явуулах шаардлагатай бол ахлах гүйцэтгэгчээс зөвшөөрөл авч ажиллагааг явуулсан тэмдэглэлд энэ тухай тусгана. Хойшлуулшгүй нөхцөл байдлын улмаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан тохиолдолд 24 цагийн дотор ахлах гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал нь төлбөр төлөгч нь иргэн бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түүний оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч; төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түүний ажил хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага нь байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр

¹² А.Лхагваа. Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2004. 115 дахь тал

гүйцэтгэгч гүйцэтгэнэ; төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ газар нь мэдэгдэхгүй бол түүний эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч; тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээр хариуцагчид даалгасан шийдвэрийг уг үйл ажиллагааг гүйцэтгэх этгээдийн оршин суугаа /оршин байгаа/ нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч; бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг төлбөр төлөгч, төлбөр авагчийн алины нь ч оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч; өөр өөр газар оршин суугаа /оршин байгаа/ хэд хэдэн төлбөр төлөгчид холбогдох шийдвэрийг төлбөр авагчийн саналаар төлбөр төлөгчдийн аль нэгний оршин суугаа /оршин байгаа/ нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч; гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой шийдвэрийг төлбөр авагчийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл төлбөр төлөгчийн эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч; тэжээн тэтгэхтэй холбогдсон шүүхийн шийдвэрийг төлбөр авагчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэдэг.

(2) ХБНГУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо

ХБНГУ-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Иргэний процессын хууль (Zivilprozessordnung – ZPO), болон Албадан худалдах, эрх шилжүүлэх тухай хуулиар (Gesetz über die Zwangsversteigerung und Zwangsverwaltung – ZVG) зохицуулдаг.¹³ Харин Шүүхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн журамд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, ажил үүргийг тодорхойлсон.¹⁴

Иргэний процессын хуулиар хуульд заасан ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлдэг. Шийдвэр гүйцэтгэх тусгай шаардлага нь гүйцэтгэх ажиллагаа явуулах эд хөрөнгөөс хамааран өөр өөр байдаг.¹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий шаардлагын хувьд төлбөр барагдуулах шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхийн тулд эхлээд төлбөр авагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулбарыг авах шаардлагатай.

¹³ How to enforce a court decision, Germany, https://e-justice.europa.eu/content_procedures_for_enforcing_a_judgment-52-de-en.do?member=1

¹⁴ All-Russian State University of Justice, State and private enforcement systems: Comparative analysis and the best practices, *Walter Gietmann, Federal Director of the Union of Bailiffs of Germany, "The German bailiff system"*, Moscow, 2019, p371-378.

¹⁵ Enforcement of Judgments Germany, <https://practiceguides.chambers.com/practice-guides/comparison/683/7154/11684-11686-11694-11701>

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах эд хөрөнгөөс хамааран ямар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахыг эрх бүхий байгууллага тогтоодог. Орон нутгийн шүүх нь шийдвэр гүйцэтгэх шүүхийн хувьд мөнгөн нэхэмжлэлийг суутгал хийх, шилжүүлэх захирамж (Pfändungs- und Überweisungsbeschluss) гаргана. Суутгал хийх, шилжүүлэх захирамж нь хоёр хэсгээс бүрдэнэ: суутгал хийх захирамж нь хариуцагчийн гуравдагч этгээдийн нэхэмжлэлийг агуулдаг; хариуцагч нь хураан авсан нэхэмжлэлийг цаашид захиран зарцуулах эрхгүй. Шилжүүлэх захирамж нь үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээдийг төлбөр авагчид төлбөрийг төлөхийг хориглодог - оронд нь төлбөр авагчид төлдөг.¹⁶

Түүнчлэн, төлбөр авагчийн хүсэлтээр үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээд нь өөрийн мэдүүлгийг өгөх ёстой. Тиймээс төлбөр авагч нь нэхэмжлэлийн шаардлага байгаа эсэх, үнэ цэний талаар мэдээлэл авах эрхтэй.

Төлбөр авагч нь төлбөр төлөгчийн өмчлөлийн зүйлээр албадан гүйцэтгэхийг хүсвэл төлбөр төлөгчийн эд хөрөнгө байгаа газрын бүртгэлийн албанд өргөдөл гаргаж, албадан барьцаалсан барьцааг газрын бүртгэлд өөрийн нэр дээр бүртгүүлнэ. Энэхүү албадан барьцаалсан барьцааны зээл нь газрын бүртгэлд бүртгэгдсэн даруйд төлбөр авагч дараагийн алхамд албадан худалдах хүсэлт гаргаж болно. Дуудлага худалдаагаар худалдах өргөдлийг төлбөр төлөгчийн дуудлага худалдаанд оруулах гэж буй дүүрэгт харьяалагдах орон нутгийн шүүхэд гаргадаг.¹⁷

Шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэл ямар ч үр дүнд хүрээгүй бөгөөд төлбөр төлөгч төлбөрийн чадамжгүй бол төлбөр төлөгчийн эд хөрөнгөд төлбөрийн чадваргүй байдлыг тогтоолгох хүсэлт гаргаж болно. Төлбөрийн чадваргүй байдлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд бүх бие даасан гүйцэтгэлийг түдгэлзүүлж, төлбөрийн чадваргүй байдлыг хариуцсан албан тушаалтанд нэхэмжлэл гаргах шаардлагатай.¹⁸ Өр төлбөрийг төлөхөд бэлэн байгаа хөрөнгө хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийг төлбөрийн чадваргүйд тооцож болно. Төлбөр төлөгч нь бэлэн мөнгөөр хүлээсэн өр төлбөрийг хугацаа дуусахад төлөхгүй нь тогтоогдвол төлбөрийн чадваргүй болно. Энэхүү процессын зорилго нь

¹⁶ Enforcement of Judgments Germany, <https://practiceguides.chambers.com/practice-guides/comparison/683/7154/11684-11686-11694-11701>

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ Мөн тэнд.

хариуцагч, компанийн хөрөнгийг албадан хураах, дампуурсан гэж зарласан иргэний орлогыг албадан авах замаар өр барагдуулахад оршино.¹⁹

Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлд зарцуулах зардал, хугацааны тухайд ХБНГУ-д шүүхийн шийдвэр гүйцэтгэх зардал маш бага бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад цаг хугацаа хэмнэж ажилладаг. Гүйцэтгэх ажиллагааны хугацаа нь төлбөр авагчийн сонгох арга хэмжээнээс хамаарна. Суутгал хийх, шилжүүлэх үйл явц харьцангуй хурдан явагддаг ч албадан барьцаалсан барьцааны зээлийг бүртгэх, дараа нь битүүмжлэх, худалдахад тодорхой хугацаа шаардагдана.

Шүүхийн ажиллагаанаас ялгаатай нь маргаантай байгаа дүнгээр зардлыг тооцдоггүй, харин шүүх буюу эрх бүхий шийдвэр гүйцэтгэх байгууллага нэг удаагийн зардлыг тооцдог ба зардал нь өмгөөлөгчийн хөлстэй харьцуулахад нэлээд бага ба бүх зардлыг төлбөр төлөгчөөс шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нэхэмжлэх боломжтой. Гэсэн хэдий ч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй явуулах урьдчилсан нөхцөл бол төлбөр авагч нь хариуцагчийн эд хөрөнгө, тэдгээрийн байгаа газрын талаарх мэдээлэлтэй байх нь эрх бүхий шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын даалгаврын дагуу ажиллах боломж олгодог. Учир нь ХБНГУ-д төлбөр төлөгч ямар хөрөнгө эзэмшиж, хаана байрлаж байгааг тогтоох шүүхийн дараах журам байдаггүй. Үүнийг тодорхой болгох нь төлбөр авагчийн асуудал бөгөөд урьдчилан мэдээлэл авах нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэс юм.²⁰

Мөнгөн өр барагдуулах дундаж хугацаа дөрвөөс найман долоо хоног байдаг бол хөдлөх хөрөнгийн журам баруун Германд зургаагаас есөн сар, зүүн Германд арван хоёр сар хүртэл үргэлжилдэг. Үл хөдлөх эд хөрөнгийн гүйцэтгэлийн тухайд шүүх, банк, хөрөнгө худалдан авагч зэргээс хамаардаг тул уг процессын шийдвэрлэх хугацааг тооцоход хэцүү байдаг.²¹

Биет бус эд хөрөнгийн гүйцэтгэлийг тухайн эд хөрөнгийн харьяалалд байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хариуцна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч зааварчилгаа авсны дараа шууд үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэх ажиллагааны нэгэн зэрэг шаардлагатай

¹⁹ Мөн тэнд.

²⁰ Мөн тэнд.

²¹ The Enforcement of a Title in Germany, https://www.mmrecht.com/claim_collection/enforcement_en.php (Сүүлд үзсэн: 2022.05.27)

үйлчилгээг ч гүйцэтгэх боломжтой тул энэхүү шийдвэр гүйцэтгэх хэрэгсэл нь харьцангуй хурдан явагддаг ч төлбөр төлөгчийн хамтын ажиллагаанаас мөн хамаарна.

Үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээдийн мэдээлэл нь төлбөр авагчид суутгал хийсэн нэхэмжлэлийн оршин тогтнол, үнэ цэний талаарх мэдээллийг харьцангуй хялбараар хангадаг тул маш үр дүнтэй байдаг.

Нөгөөтэйгүүр, биет бус хөрөнгө эсвэл үл хөдлөх хөрөнгийн албадлагын гүйцэтгэл нь маш их цаг хугацаа шаарддаг, барьцааны зүйлийг албадан худалдах тухайд шийдвэр гүйцэтгэл нэг жил эсвэл түүнээс дээш хугацаа шаардагддаг. Үл хөдлөх эд хөрөнгийн албадан гүйцэтгэл нь илүү өртөг өндөр, төвөгтэй бөгөөд бүртгэлийн хуулбарыг авах, түүнчлэн хөрөнгийг худалдах, хураах хүртэл урт хугацаа шаардагддаг.²² Нэмж дурдахад, зарим тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргахад шаардагдах зардлыг төлбөр авагчаас эхлээд гаргах шаардлагатай байдаг тул гарсан зардал нь бусад төрлийн албадлагын гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр байдаг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хариуцагч өөрийгөө өмгөөлж, улмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь хойшлуулж, төлбөр авагчийг хохироох боломжтой. Нөгөөтэйгүүр, үл хөдлөх эд хөрөнгийн албадлагын гүйцэтгэл нь төлбөр төлөгчийн зээлжих чадварыг (жишээлбэл, санхүүжүүлэгч банкттай) эрсдэлд оруулж болзошгүй тул төлбөр төлөгчид дарамт үзүүлэх өндөр үр дүнтэй арга хэрэгсэл юм.²³

Шийдвэр гүйцэтгэлийн зардлыг тооцохдоо шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нэхэмжлэлийн үнийг тогтооход ашигладаг хүснэгтэд үндэслэн өөрийн зардлыг тооцдог. Жишээлбэл, 100 000 еврогийн нэхэмжлэлийг авч үзвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн зардал 560 орчим евро байна.²⁴

Шийдвэр гүйцэтгэх эрх бүхий анхан шатны шүүх нь хөдлөх эд хөрөнгийн нэгэн адил үл хөдлөх хөрөнгийн эсрэг нэхэмжлэлийн шаардлага (шүүхийн хураан авах, албадан дуудлага худалдаа)-ыг шийдвэрлэх үүрэгтэй.²⁵ Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахаар хариуцагчийн оршин суугаа газрын орон нутгийн шүүх, арга хэмжээ авах буюу түүнээс татгалзах албадлагын арга хэмжээний хувьд зохих анхан шатны шүүхэд гаргадаг бол

²² Мөн тэнд.

²³ Мөн тэнд.

²⁴ The Enforcement of a Title in Germany, https://www.mmrecht.com/claim_collection/enforcement_en.php (Сүүлд үзсэн: 2022.05.27)

²⁵ The actors of enforcement, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-2-actors-enforcement-1>

албадан худалдах, хураан авах тохиолдолд тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд ханддаг.²⁶

Газар бүртгэлийн газар (Land Registry) нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бас нэгэн чухал субъект бөгөөд шүүхийн газрын бүртгэл хөтлөх үүрэгтэй төрийн байгууллага юм. Газрын бүртгэлийн хуулийн (Grundbuchordnung "GBO") 1 I дүгээр зүйлийн дагуу газрын бүртгэлийг орон нутгийн шүүх хөтөлдөг. Газрын бүртгэл нь үл хөдлөх хөрөнгө, түүний нэг хэсэг болох ипотекийн бүртгэлийг хариуцдаг. Үүнээс үл хамааран шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон албадан дуудлага худалдаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх бүхий шүүхийн харьяалалд хамаарах тул (Албадан дуудлага худалдаа ба шүүхийн хураан авах тухай хуулийн §1 I): "Орон нутгийн шүүх нь тухайн нутаг дэвсгэрт албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх бүхий шүүх юм. Тухайн газар хаана байрлаж байгаа нь шүүхээр битүүмжлэх, албадан дуудлага худалдаанд оруулна."²⁷

Иргэний процессын хуулийн 866 дугаар зүйлд зааснаар газраар шийдвэр гүйцэтгэх тохиолдолд 750 еврогоос дээш хэмжээний мөнгөн нэхэмжлэлийн барьцааг бүртгэх замаар шийдвэр гүйцэтгэнэ. Барьцааг төлбөр авагчийн хүсэлтээр газрын бүртгэлд оруулна (§ 867). Шүүхийн бүртгэгч нь газрын бүртгэлтэй холбоотой хэргийг хариуцдаг (RPflG-ийн § 3 № 1h (Шүүхийн бүртгэлийн ажилтны үүргийн тухай хууль)). Гэсэн хэдий ч барьцааны хэрэгжилт нь барьцааны бүртгэлээр дуусдаггүй. Төлбөр авагч нь шүүхээр хураан авах эсвэл албадан дуудлага худалдаанд оруулах хүсэлт гаргаж, улмаар хөрөнгийн үнэ цэнийг мэднэ. Мөн төлбөр төлөгч гүйцэтгэх шаардлагын эсрэг эсэргүүцэл гаргаж болно (§767 Гүйцэтгэх ажиллагааны эсрэг хамгаалалт).²⁸

(3) БНСУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо

БНСУ-ын иргэний хууль тогтоомж нь Иргэний хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиас бүрдэнэ.

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 1960 онд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг байсан бол 2002 онд Иргэний шүүхийн

²⁶ How to enforce a court decision, Germany, https://e-justice.europa.eu/content_procedures_for_enforcing_a_judgment-52-de-en.do?member=1

²⁷ The actors of enforcement, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-2-actors-enforcement-1>

²⁸ Мөн тэнд.

шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хууль батлагдсанаар бие даасан хуулиар зохицуулдаг болжээ. Учир нь төлбөр авагч, төлбөр төлөгч хуулийн хийдлийг ашиглах, шүүхийн шийдвэр гүйцэтгэл удаашрахаас хамгаалах, төлбөр төлөгчийн хариуцлагыг дээшлүүлэх замаар шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй, түргэн шуурхай болгох нийгэм, эдийн засгийн шаардлага бий болсон байна.

БНСУ-д 2020 онд иргэний хэргийн анхан шатны шүүх 4.711.045 хэрэг шийдвэрлэснээс 1.279.977 шүүхийн тогтоолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгджээ. Энэ дүн нь өмнөх жилийнхтэй харьцуулахад 15.3 хувиар нэмэгдсэн байна.²⁹

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн зорилго нь албадан гүйцэтгэх, барьцааны эд хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулах, Иргэний хууль болон Худалдааны хууль, бусад хууль тогтоомжид заасан дуудлага худалдаа, нэмэлт шийдвэр (битүүмжлэх г.м)-тэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь тухайн хэргийг харьяалан шийдсэн шүүх өөрөө байх бөгөөд шүүхэд тухайн шийдвэрийг гүйцэтгэгч (집행관) буюу шүүхийн албан хаагч ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, БНСУ нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд шүүхийн тогтолцоотой улс юм.

(4) Япон улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоо

Япон улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа нь өөрийн гэсэн онцлогтой бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчийг “civil execution officer” буюу shikkori (шикори) гэж нэрлэдэг байсан³⁰. Эзэнт гүрний үед 1886 онд Эзэн хааны зарлигаар анхны үндэсний шүүхийн шийдвэрийг биелүүлэх тогтолцоог бий болгосон гэж үздэг байна. Энэхүү тушаалд шийдвэр гүйцэтгэгч (shikkori) шүүхээс гаргасан баримт бичгийг холбогдох этгээдэд хүргэх үүрэгтэй бөгөөд шүүхийн биелэлтийг хангах үүрэгтэй гэж заасан. Тэднийг томилох арга, ажиллах нөхцөл нь нууц байсан байх ба энэхүү албан тушаалыг Пруссийн Герихцволзиехерийн шуудан эсвэл Францын hussier-ийг дурайлган загварчилсан гэж үздэг³¹. Харин 1890-ээд оноос shikkori гэсэн нэршил нь shittatsuri хэмээн өөрчлөгдөж,

²⁹ 법원행정처, 2021 사법연감, 617 면.

³⁰ Bennett, F. (1999). Civil Execution in Japan: the legal economics of perfect honesty. *Nagoya University Law Review*, 177.

³¹ Shimomura, M. (2010). Civil Execution System and Insolvency System. Available at SSRN 1612704.

улмаар тус шийдвэр гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага өргөжиж эхэлсэн байна. Тус албан хаагчид нь тус тусын дүүргийн харьяаллын дагуу ажил үүргээ гүйцэтгэдэг байсан бөгөөд оффис нь шүүхийн гадна байрладаг буюу шүүхээс хараат бус, бие даасан статустай байсан. Улмаар 1966 онд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн талаарх эрх үүрэг, болон цалингийн системийн талаар маш нарийвчлан анхаарч үзсэнээр Shikkokan Act батлагдаж, иргэний шүүхийн биелэлтэд түргэн шуурхай арга хэмжээ авах зорилгоор албан шууд нэхэмжлэгч нартай хувийн гэрээ байгуулан ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн онцлогтой. Улмаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулан төлбөр авагчид өр барагдуулах хүсэлтээ Шиттацурид шууд гаргаж өгөх боломж бүрэлдсэн. Гэвч энэхүү талуудын гэрээгээр явагддаг шүүхийн шийдвэр биелүүлэх тогтолцоо нь маш түргэн шуурхай явагдах болсон ч зах зээлийн зарчмаар шийдвэр гүйцэтгэгчдийг маш өндөр үнээр хөлсөлдөг болж, улмар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал улам ихсэж, нийгэмд шүүхийн биелэлтийг биелүүлэх нэрийдлээр хуулийн дор хүчирхийлэл, заналхийллийг өөгшүүлж байна гэж судлаачид үзэж, шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж байв³². Улмаар хуулийн шинэчлэлийн хүрээнд 1966 оны Шикко-кан хууль (Shikkô-kan Act of 1966) батлагдаж, урамшуулал, санхүүжилтын тогтолцоо бүрэн хэвээр үлдсэн боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтнуудын сонгон шалгаруулах үйл явц эрс өөрчлөгдөж; иргэний шийдвэр гүйцэтгэх албан тушаалтнуудад хууль ёсны шинэ нэршил олгохоос гадна шийдвэр биелэлтийн үйл ажиллагаанд шүүхийн хяналтыг чангатгасан онцлогтой. Мөн Шикко-каныг Дүүргийн шүүх дотор байршуулж, сургалтын тогтолцоог нэвтрүүлж, нарийвчилсан сонгон шалгаруулалтаар сонгодог болсон бөгөөд шийдвэр гүйцэтгэх үүргээ бусдад шилжүүлэхийг хуулиар хориглосон байна. Мөн шинэ журмаар зөвхөн төрийн албаны 7-оос дээш зэрэгтэй, 40-өөс дээш насны төрийн албан хаагчид ажилд орох өргөдөл гаргах эрхтэй болсон боловч энэ тус салбарт ажиллах хүн хүчний тоог мэдэгдэхүйц бууруулсан байна. 1997 оны байдлаар 512 шүүхийн шийдвэр гүйцэтгэгч үндэсний хэмжээнд байсан бол нэг шийдвэр гүйцэтгэгчид 470 хэрэг оноогддог байсан байна.

Одоогоор Шүүхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх журам, болон Иргэний хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай эрх зүйн орчныг тусган зохицуулсан байна. Япон улс нь “Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийг (Civil

³² Bennett, F. (1999). Civil Execution in Japan: the legal economics of perfect honesty. *Nagoya University Law Review*, 177.

Execution Act) 1979 оны 3 дугаар сарын 30-ны өдөр баталж, 1980 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс дагаж мөрдсөн бөгөөд 4 бүлэг 198 зүйлтэй. Тус хуулиар шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг зохицуулсан байдаг бөгөөд энэ хуулиар Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэхээр мөн заажээ. Гадаадын шүүхийн шийдвэрийг Японы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хуулийн дагуу хэрэгжүүлэх боломжтой. Харин гадаадын арбитрын шийдвэрийн Японы Арбитрын хуулийн дагуу төлбөр төлөгч шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шийдвэр гарсны дараа уг хуулийн дагуу албадан гүйцэтгэдэг байна.

(5) Испани улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоо

Шүүхийн ажилтны загвар хөгжих хүртэл шүүх төвтэй гүйцэтгэх ажиллагаа нь Европт хамгийн өргөн тархсан загвар байсан бөгөөд Испани улс уг загварт хамаарах орнуудын нэг юм. Испанид хэдэн зууны турш Ромын эрх зүй хүчтэй нөлөөлсөн ч Арабын засгийн газрын үе (711 оноос) болон эртний Реконкистагийн үед Испанийн хаант улсуудад ёс заншил, үйл явцын эртний хэлбэрүүд дэлгэрч, эдгээр нь эргээд 2008 онд роман-каноник журмаар солигдсон. Испанид шүүхүүдийг Жузгадо, Трибуналес³³ гэж нэрлэдэг. Уламжлал ёсоор тус бүр нь шүүгч ба түүний захиргааны дэмжлэг болох шүүхийн албанаас бүрдэж, модульчлагдсан бүтцийг бий болгодог. Уламжлалт шүүхийн албыг Шүүхийн нарийн бичгийн дарга хянадаг байв.³⁴

Цагаан ном болон Төрийн Пакт дахь зөвлөмжийн дагуу шүүхийн захиргааны шинэ арга барилыг аажмаар боловсруулж, "Шинэ шүүхийн алба" (La Nueva Oficina Judicial)-ыг хэрэгжүүлсэн. Эхний алхамаар өргөн хүрээтэй өөрчлөлт хийж, шүүхийн Тамгын газрын шинэ бүтцийг нэвтрүүлж, Шүүхийн нарийн бичгийн дарга нар болон бусад захиргааны ажилтнуудын үүргийг дахин тодорхойлж, төрөл бүрийн мэргэжлийн бүлгүүдийг байгуулсан.

Шинэ шүүхийн алба нь нэмэлт өөрчлөлт оруулсан Шүүхийн тухай хууль (Ley Organica del Poder Judicial)-ийн 435 дугаар зүйлд заасны дагуу үндэсний нутаг дэвсгэр даяар нэгэн төрлийн бүтэцтэй байна. 436 дугаар зүйлд зааснаар шүүхийн тамгын газрын бүтцийн үндсэн зохион байгуулалтын нэгж нь оногдсон чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж байдаг.

³³ (Juzgados and Tribunales) Жузгадо нь дан шүүгчтэй шүүх (нэг хүний эрх мэдэл) бөгөөд Tribunal нь олон шүүгчтэй шүүх юм.

³⁴ Wendy Kennett, *Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge*, 2021, page 459

Испанийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг зохицуулдаг гол хууль тогтоомж нь нэлээд өргөн цар хүрээтэй байдаг. Гол хууль тогтоомж нь Испанийн Процессын хууль боловч бусад актуудад зарим асуудлыг зохицуулсан тусгай заалтууд байдаг.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэхийн тулд бүрэн хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх шаардлагатай. Испанид шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхэд өргөдөл гаргаснаар эхэлдэг. Зарчмын хувьд төлбөр төлөгчийн эзэмшилд байгаа хөдлөх эд хөрөнгө нь тэдний өмчлөлд байдаг. Гуравдагч этгээд эд хөрөнгөө нэхэмжлэх эрхтэй бөгөөд эдгээр нэхэмжлэлийг бараа материалын тайланд тэмдэглэсэн байдаг ба гуравдагч этгээд өмчлөх эрхээ шүүхэд нотлох ёстой.³⁵

Испани мэдээллийн технологид хөрөнгө оруулж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгосны үр дүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай өргөдөл, шүүх хоорондын харилцаа холбоо, мэдээлэл авах хүсэлт, хураан авах тодорхой хэлбэр, битүүмжилсэн эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах зэргийг цахим хэлбэрээр явуулах боломжтой болсон.³⁶

(6) Швед улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоо

Европын холбоонд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх агентлаг зөвхөн Швед болон Финланд улсуудад байдаг. Швед улсын засаг захиргааны тогтолцоо нь “дуалист”: Ерөнхий сайд Засгийн газрын харьяа хэлтсүүдийг ахалдаг бөгөөд Засгийн газрын тамгын газар (*“Regeringsformen”*)-т харьяалагддаг бүтэцтэй бол засгийн газрын төвлөрсөн үйл ажиллагааны дийлэнхийг даасан төрийн агентлагууд гүйцэтгэдэг.³⁷

Швед улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх журам, Үйлчилгээний тухай хууль, Швед улсын Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Төлбөр төлөх, гүйцэтгэх тусламж шаардах тухай хууль зэрэг хууль тогтоомжууд хэрэгждэг.

³⁵ European Union’s Justice Programme, Civil enforcement in the EU: a comparative overview, 2021 <https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>

³⁶ Wendy Kennett, Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge, 2021, page 459

³⁷ Мөн тэнд, 127 дахь тал

Швед улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (ШШГГ) нь шүүхийн шийдвэр болон бусад шийдвэр гүйцэтгэх эрхийг хэрэгжүүлэх зорилгоор албадлагын арга хэмжээ авах эрх бүхий субъект нь төрийн байгууллага юм. Түүхэн хөгжлийг нь харвал хянан харгалзаж буй хэргийн гуравны хоёр орчим нь төрийн хуулийн өртэй холбоотой байдаг. Хэдийгээр албадлагын арга хэмжээ практикт ховор тохиолддог боловч ШШГГ нь жилд дунджаар 2 сая өргөдөл, үүний 500,000 орчим нь төлбөр төлөгчид хамаардаг бөгөөд тэдгээрийн 85 хувь нь иргэд байдаг.

1997 оноос өмнө шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүс нутаг, хотын захиргаа гүйцэтгэдэг байсан бол үүнээс хойш 10 бүс нутгийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж байсан. Мөн шүүхэд нийтийн хуулийн нэхэмжлэлийг хэрэгжүүлэхэд төлбөр авагчийн үүрэг гүйцэтгэж, гүйцэтгэлийг хариуцдаг байв. Харин 2003 онд холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулж чиг үүргийг салгажээ. Ийнхүү 2008 онд ШШГГ нь Сангийн яамны харьяа агентлаг болсон байна.³⁸

Одоогоор ШШГГ нь 37 оффистой, 2100 орчим албан хаагчтай. Нэхэмжлэлийг аль ч оффис дээр гаргаж болох бөгөөд цааш нь холбогдох албанд шилжүүлдэг. Риксронефогден тэргүүлдэг бөгөөд Зөвлөлийн 12 гишүүнтэй. Ахлах удирдлагын багийн доор хэд хэдэн нэгж байдаг бөгөөд тэдгээрийн хамгийн том нь ШШГГ-ын хариуцах үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг. Бусад нэгжүүд нь мэдээллийн технологи, санхүү, нягтлан бодох бүртгэл, хүний нөөц, хөгжил, харилцаа холбоо, мэргэшсэн хуулийн зөвлөгөө зэрэг үйл ажиллагааг явуулдаг байна.

1877 онд батлагдсан Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хүчингүй болгон 1982 оны 1-р сарын 1-нд уг хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд тус хуулийн дагуу ШШГГ иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг гүйцэтгэдэг.

Европын холбооны гишүүн орнуудын дунд нийтийн эрх зүйн өрийг шууд хураан авах ажлыг хөнгөвчлөх чиглэлээр илүүтэй анхаарч байгаа бөгөөд төрийн эрх бүхий байгууллагад шийдвэр гүйцэтгэх эрх олгох хүрээг тэлэх чиг хандлагатай байна.³⁹

³⁸ Мөн тэнд, 138 дахь тал

³⁹ Мөн тэнд, 154 дэх тал

Eurofound-ийн "Өрхийн хэт өрийн асуудлыг шийдвэрлэх нь" тайланд Швед улсыг амьжиргаагаа залгуулах асуудал, өрийн үлдэгдэл хамгийн бага (6 хувь) гэж тодорхойлжээ.

ШШГГ нь ядуурал, хэт өртэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд өрийн асуудлыг өргөн хүрээгээр хардаг ба өр төлбөрөөс урьдчилан сэргийлэх боловсрол олгохоос гадна өр төлбөрөөс чөлөөлөх журмыг мөн хариуцдаг нь бодлого боловсруулахад чухал хувь нэмэр оруулдаг.

Урьдчилан сэргийлэх ажил нь хэт өртэй тэмцэх, урт хугацааны, тогтвортой хувийн санхүүгийн шийдвэр гаргахад туслах хамгийн боломжит хүмүүст чиглэгддэг. Үүнд багш, хотын өрийн зөвлөхүүд, хорих анги, тэнсэн харгалзах албаны ажилтнууд багтдаг. Сүүлийн жилүүдэд залуучуудын өрийг бууруулах асуудалд онцгой анхаарал хандуулж, урьдчилан сэргийлэх ажлынхаа зарим хэсгийг сургууль, эцэг эхчүүдэд зориулсан дуу, дүрс бичлэгээр дамжуулан хүргэж байна.

IV. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

(1) Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

Төрөөс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудыг үйл ажиллагаагаа хараат бус, үр дүнтэй явуулах эрх зүйн болон нийгмийн баталгааг бүрдүүлж шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад түүний албан хаагчийн ажиллах, нөхцөл, эрх зүйн болон нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалан хангахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох нь төрийн үүрэг юм.⁴⁰ Монгол Улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн албаны тухай хуулиудаар зохицуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 270 дугаар зүйлийн 270.3 дахь хэсэгт зааснаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман

⁴⁰ Г.Агар-Эрдэнэ, Зарим орнуудад шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн болон нийгмийн баталгааг бүрдүүлсэн байдал, <http://resource3.sodonvision.com/courtservice/file/2013/5/vyv25zucdca11en0d4clusfm/12.Shuuhiiin%20shiidver%20quitsetgegchiin%20erh%20zuin%20batalgaa%20HEUK%20G.Agar-erdene.pdf>

насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэн шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын алба хаагчаар ажиллана.

Шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичиг нь тодорхой бус байгаа тохиолдолд түүнийг тодруулахаар шүүхэд хүсэлт гаргах; төлбөр төлөгч хуулийн этгээд, төлбөр төлөгч-иргэний, эсхүл бусад этгээдийн орон байр, агуулахад нэвтрэн орох, биед болон эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх; эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах, нуугдмал хөрөнгө илрүүлэх, хураагдсан эд хөрөнгийг худалдан борлуулах; банк, банкны бус санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, бусад үнэт зүйлийг битүүмжлэх; харилцах данснаас хасалт хийх, цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийх, бусдад байгаа өмч хөрөнгөөс төлбөр гаргуулах, шийдвэр гүйцэтгэхтэй холбогдуулан иргэн, албан тушаалтныг дуудан ирүүлэх; холбогдох иргэн, байгууллага, албан тушаалтнаас баримт, тайлбар, танилцуулга гаргуулан авах; шийдвэр гүйцэтгэх явцад эрүүгийн хэргийн шинж бүхий баримт илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх; шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар талуудаас гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх; шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа тусгай хэрэгсэл хэрэглэх бүрэн эрхтэй байдаг. Түүнчлэн хуульд заасан нийгэм, улс төр, хууль зүй, эдийн засгийн баталгааг эдэлдэг байна.

(2) ХБНГУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч гэдэг нэр томъёо 1815 оноос хойш оршин тогтнож байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоог анх Францын Хуиссиерийн загварт үндэслэн Францын Иргэний хуулийн үндсэн дээр боловсруулжээ. Үүний дараагийн хоёр зуун жилийн хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч гэсэн нэр томъёо бий болсон.⁴¹

ХБНГУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэгч (Gerichtsvollzieher) нь шүүхийн шийдвэр болон шүүхийн бусад албадлагыг хэрэгжүүлдэг⁴² ба шүүх эрх мэдлийн нэг хэсэг юм. 1877 онд Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дараа одоогийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн үндэс суурь нь Шүүхийн тухай хуулийн 154, 155-р зүйлд тусгагдсан бөгөөд өнөөг хүртэл хүчинтэй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн үйл ажиллагааны нэмэлт

⁴¹ All-Russian State University of Justice, State and private enforcement systems: Comparative analysis and the best practices, *Walter Gietmann, Federal Director of the Union of Bailiffs of Germany, "The German bailiff system"*, Moscow, 2019, p371-378.

⁴² The Enforcement of a Title in Germany, https://www.mmrecht.com/claim_collection/enforcement_en.php (Сүүлд үзсэн: 2022.05.27)

үндэс нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 753-р зүйл байдаг. ХБНГУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэгч бол төрийн албан хаагч бөгөөд тус улс нь холбооны зарчмаар зохион байгуулагдаж, шударга ёсыг тогтоох нь холбооны муж улсуудын үүрэг хариуцлага байдаг тул шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид холбооны мужуудын албан тушаалтнаар ажилладаг. Энэ нь ХБНГУ-д улсын хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн нэгдсэн алба байхгүй ч холбооны 16 муж шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийнхээ бие даасан зохион байгуулалтын бүтцийг боловсруулж, хэрэгжүүлдэг гэсэн үг юм.⁴³

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээр томилогдох насны доод хязгаар нь 25 нас байна. Харин 27 наснаас хойш насан туршдаа төрийн албан хаагч байх ба хэрэв ажил мэргэжлийн улмаас хэрэгт холбогдож яллагдагчаар татагдвал албан тушаалаас нь чөлөөлнө. Нэг жилээс дээш хугацаагаар хорих ял авсан тохиолдолд төрийн албан хаагчийн статусаа алдах ба бусад тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч байхаа болих ч шүүхийн байгууллагад үргэлжлүүлэн ажиллаж болно.⁴⁴

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн журам (GVO) нь Герман дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг. Ингэхдээ хариуцлагын асуудлаас гадна зохион байгуулалт, ёс зүйн асуудлыг тусгайлан зохицуулдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид шүүхийн байранд байрладаггүй, харин өөрсдийн харьяалах шүүхийн гадна хувийн оффистой байдаг тул хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн оффисын зохион байгуулалтын талаар бөгөөд тохиромжтой оффис түрээслэх, барих, засвар үйлчилгээ хийхээс гадна оффисын ажилчдыг ажилд авах, ажиллуулах зэрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид өөрсдийн зардлаар ажлаа зохион байгуулах ёстой гэж заасан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид байгууллагын үйл ажиллагаагаа өөрсдөө зохион байгуулж, эдийн засгийн хувьд уялдуулах ёстой учраас төрийн албан хаагч төдийгүй хувиараа бизнес эрхлэгчид тооцогддог. Ихэнхдээ хэд хэдэн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид нэгдэж, хамтарсан алба байгуулдаг ч хүн бүр өөрийн хариуцах чиглэлээр ажилладаг.⁴⁵

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид тогтмол цалингаас гадна үйлчилгээ, гүйцэтгэх захирамжийн хураамжийн тодорхой хувийг улсаас авдаг. Мөн тогтсон цалингаас гадна шөнө, оройн цагаар эсвэл амралтын өдрүүдээр ердийн ажлын цагаас гадуур хийсэн

⁴³ All-Russian State University of Justice, State and private enforcement systems: Comparative analysis and the best practices, *Walter Gietmann, Federal Director of the Union of Bailiffs of Germany, "The German bailiff system"*, Moscow, 2019, p371-378.

⁴⁴ Мөн тэнд.

⁴⁵ Мөн тэнд.

ажилдаа нэмэгдэл хөлс (шийдвэр гүйцэтгэх хураамж) авдаг. Оффисын зардлыг санхүүжүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн цалин хөлсийг төлөх журам нь улс орон даяар харилцан адилгүй, холбооны мужуудад өөр өөр бүтэцтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид ажлын тогтсон цагаар ажилладаггүй, харин долоо хоногт хоёр удаа албан өрөөндөө хувийн зөвлөгөө өгөх цагтай байдаг. Мөн анхан шатны үйлчилгээ, шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаагаа явуулахдаа шүүхийн бие даасан байгууллагын үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зөвхөн тухайн эрх бүхий шийдвэр гүйцэтгэх шүүхийн хяналтад байдаг. Энэ утгаараа шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид бие даан ажилладаг, албан үүргээ гүйцэтгэхдээ дээд албан тушаалтнаас ямар нэгэн зааварчилгаа авдаггүй. “Шийдвэр гүйцэтгэх тогтоол”-д талуудын аль нэг нь давж заалдан гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хэрэгт зөв, буруу ажилласан эсэхийг зөвхөн шийдвэр гүйцэтгэх шүүхийн шүүгч шийдвэрлэж, зохих захирамжийг гаргана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийг дээд шатны шүүхээс дүүргийн шүүхүүдэд томилж, харьяа дүүргийн шүүхүүдийн суурин дүүрэг/шийдвэр гүйцэтгэх тойрогт ажил үүргээ гүйцэтгэнэ. Эдгээр дүүргүүдийн төлөвлөлтийг дүүргийн шүүхийн дарга тухайн дүүрэгт ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран хийдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх нэг дүүрэгт дунджаар 15,000-20,000 оршин суугч байдаг бөгөөд нэг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч дангаараа хариуцдаг.⁴⁶

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид дараах асуудлаар ажилладаг:

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тохиролцож, хэсэгчлэн олгох замаар эвийн журмаар шийдвэрлэхийг оролдох;
- Мөнгөний нэхэмжлэлийн (торгууль, алдангийг оролцуулан) эд хөрөнгийн албадлагын гүйцэтгэл, барьцааны зүйлийг худалдан авах;
- Хариуцагчийн эд хөрөнгийн мэдээлэл, мэдүүлгийг хүлээн авах;
- Гуравдагч этгээдээс хариуцагчийн хөдөлмөрийн харилцааны тухай мэдээлэл эсвэл одоогийн банкны дэлгэрэнгүй мэдээлэл авах;
- Төлбөр төлөгчийг төлбөр төлөгчийн бүртгэлд бүртгүүлэх тушаал;
- Иргэний баривчлах тогтоол биелүүлэх;

⁴⁶ Мөн тэнд.

- Хөдлөх эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө (жишээ нь, орон сууц, бизнесийн байрыг албадан нүүлгэх) болон хүмүүсийг хүлээлгэн өгөх (жишээ нь, хүүхдүүдийг нүүлгэн шилжүүлэх) нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх;
- Захирамж/захиалга, баривчлах ажиллагааг гүйцэтгэх;
- Үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах (жишээлбэл, хариуцагчийн банкны дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах);
- Шүүхэд оролцох хүсэлт (иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гэрч, хариуцагч гэх мэт) гаргах;
- Талуудын санаачилгаар буюу шүүхийн шийдвэрээр, ихэвчлэн шийдвэр гүйцэтгэх шүүхийн мэдүүлэг өгөх;
- шүүхийн шийдвэрээр цагдан хорих, битүүмжлэх;
- Эсэргүүцлийг тооцох, шалгах;
- Германы Иргэний хуулийн дагуу дуудлага худалдааг явуулах.

Үүнээс мөнгөний нэхэмжлэлийн шийдвэр гүйцэтгэлийг биелүүлэх нь ХБНГУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллын 80-90 орчим хувийг эзэлдэг байна.⁴⁷

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг 06-21 цагийн хооронд явуулдаг. Харин шөнийн цагаар болон амралтын өдрүүд, нийтээр амрах баярын өдрүүдээр шүүхийн шийдвэр гүйцэтгэл явуулах тохиолдолд дүүргийн шүүхээс зөвшөөрөл авдаг.⁴⁸

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн хооронд аливаа өрсөлдөөнийг зөвшөөрдөггүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь зөвхөн албан ёсны үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэж болох бөгөөд бусдад шилжүүлэхийг хориглоно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид орон сууц албадан нээх тохиолдолд хоёр ажилтан эсвэл цагдаа, олон нийтийн ажилтныг байлгах ёстой гэх зэрэг зохицуулалттай.⁴⁹

⁴⁷ All-Russian State University of Justice, State and private enforcement systems: Comparative analysis and the best practices, ANDREAS ZEDEL, *High bailiff at the District Court of Eisenach/Thuringia*, "The departmental responsibilities of the German bailiff - En transformation process from seizure and recovery to information gathering", Moscow, 2019, p564-568.

⁴⁸ Civil enforcement in the EU: a comparative overview, Comparative Report, <https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>

⁴⁹ Мөн тэнд, p371-378.

(3) БНСУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

Шүүхийн тухай хууль (ШтХ)-ийн 55 дугаар зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх эрх зүйн байдлыг тодорхойлсон байдаг. ШтХ-ийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт бүс нутгийн шүүх болон түүний харьяа шүүх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэгчтэй байхаар, мөн зүйлийн 55.2 дахь хэсэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь хуульд заасны дагуу шүүхийн үйл ажиллагааг гүйцэтгэх, баримт бичиг илгээх, бусад чиг үүргийг гүйцэтгэхээр, 55.3 дахь хэсэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь албан үүргээ шударгаар гүйцэтгэхээ илэрхийлэн бүс нутгийн шүүхэд барьцаа байршуулахаар тус тус заажээ. Мөн зүйлийн 55.4-д 55.3-т заасан барьцаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хураамжтай холбогдох зүйлийг дээд шүүхийн журмаар тогтоох юм.

Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхийн тулд шаардлагатай тохиолдолд төлбөр төлөгчийн орон байр, агуулах, бусад газарт нэгжлэг хийх эрхтэй. Энэхүү шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч эсэргүүцэл үзүүлэх тохиолдолд цагдаа, цэргийн байгууллагаас туслалцаа авах боломжтой байна. Цэргийн тусламж хүсэх тохиолдолд тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхэд хүсэлт гаргах бөгөөд шүүх тус хүсэлтийг Дээд шүүхийн дүрмийг баримтлан шийдвэрлэнэ. Мөн шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад дарамт, шахалтад орох эсхүл төлбөр төлөгчийн орон байранд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тохиолдолд хөндлөнгийн гэрчийг оролцуулах бөгөөд төлбөр төлөгчийн төрөл садан, ажлын газрын даргыг байлцуулах, эдгээр оролцогчтой уулзах боломжгүй тохиолдолд эрх зүйн чадамжтай хоёр хүн эсхүл хот, дүүрэг, хорооны албан хаагч, цагдаагийн байгууллагын албан хаагчийг байлцуулна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрт үндэслэн албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах бөгөөд уг ажиллагаанд төлбөр авагч болон үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээдийг төлөөлөхгүй юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах тохиолдолд зогсоож эсхүл түдгэлзүүлж болно (ИШГАтХ-ийн 49 дүгээр зүйл). Үүнд:

- Шүүхийн шийдвэр хүчингүй болох, албадан гүйцэтгэх баримт бичгийг шүүх бүрэлдэхүүнээс олгоогүй;
- Шүүх бүрэлдэхүүн албадан гүйцэтгэлийг зогсоох шийдвэр гаргасан;
- Төлбөр төлөгч барьцаа байршуулан баталгаа авсан;

- Шүүхийн шийдвэрийн дараа төлбөр төлөгч төлбөр авагчийн нэхэмжлэлийг хангасан эсхүл төлбөр авагчийн шаардлагыг барагдуулахаар тохиролцсон гэрээ байгуулсан;
- Шүүхийн шийдвэр хүчингүй болсон;
- Төлбөр авагч шүүхэд гаргасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай өргөдлөө татан авсан зэрэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зардлыг төлбөр төлөгчөөс гаргуулах бөгөөд хэрвээ шүүхийн шийдвэр хүчингүй болох тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн явцад гарсан зардлыг төлбөр авагч хариуцна.

(4) Япон улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг Япон улсын Шүүхийн тухай хуульд⁵⁰ зааснаар “Шүүхийн шүүгчээс бусад албан тушаалтнуудын төрөл”-д ангилан авч үзэхээр заасан байна. Тус хуулийн 2-р бүлгийн 62-р зүйлд зааснаар :

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтнууд:

- (1) Дүүргийн шүүх бүрт шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчид байна.
- (2) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтнаар томилогдоход шаардагдах шаардлагыг Дээд шүүх тогтооно.
- (3) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхээс гаргасан баримт бичгийг хүргэх, бусад хуульд заасан бусад ажлыг удирдан зохион байгуулна.
- (4) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтан нь урамшуулал авна. Хэрэв урамшуулал нь хуулиар заасан хэмжээнд хүрэхгүй байгаа тохиолдолд Сангийн яамнаас нөхөн төлбөр олгогдоно” хэмээн тус тус хуульчлан заасан байна.

Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтнууд нь шүүхээс бие даасан бус харин шүүхэд харьяалагддаг байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь тусдаа статустай гүйцэтгэх засаглал бус харин шүүх эрх мэдлийн нэг хэсэг юм. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн санхүүжилтийн системийг хуульчлан зохицуулсан байх бөгөөд их мөнгөн дүнтэй хэргийн шийдвэрийг гүйцэтгэснээр шийдвэр гүйцэтгэгчид илүү ашигтай байх

⁵⁰ Court Act (Act No. 59 of 1947

https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3900/en#je_pt4ch2

тогтолцоог нэвтрүүлсэн нь маш онцлогтой байна. Өөрөөр хэлбэл, их мөнгөн дүнтэй нэхэмжлэлтэй шүүхийн шийдвэр аль болох түргэн шуурхай гүйцэтгэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байгааг онцлох нь зүйтэй. Улмаар, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 6 дугаар зүйлийн 1-д зааснаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэх явцад эсэргүүцэлтэй тулгарвал түүнийг арилгахын тулд хүч хэрэглэж, цагдаагийн байгууллагаас тусламж хүсэж болно” хэмээн заасан байна.

Мөн Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд⁵¹ дараах байдлаар илүү дэлгэрэнгүй хуульчлан зохицуулсан байна. Шийдвэр гүйцэтгэх агентлаг:

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтээр гүйцэтгэнэ.

3 дугаар зүйл. Иргэний хэргийн шүүх харьяалагдах шүүхийн шийдвэрийг шүүх, харин шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн харьяалагдах гүйцэтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх гэдэг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчид харьяалагдаж буй дүүргийн шүүхийг ойлгоно.

Дээрх заалтаас үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх үүргийг шүүх дангаараа хийж болох тухай хуульчлан заасан байх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх гэдэг нь Дүүргийн шүүхийг ойлгохоор албан ёсоор хуульчлан заасан байгааг онцлох нь зүйтэй. Энэ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэгч болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх гэж тусад нь ангилж тухайлан гүйцэтгэх хэргүүдийг нэг бүрчлэн ангилан авч үзсэн байна.

(5) Испани улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

Испанид шүүхийн ажилтнуудыг шууд удирддаг шүүхийн алба (oficina judicial) нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилладаг. Уг алба нь нийтлэг процессын үйл ажиллагаануудад шууд дэмжлэг үзүүлэх нэгжтэй байдаг.⁵²

Засгийн газрын нарийн бичгийн дарга нар нь Хууль зүйн сайдын тушаалаар томилогддог шүүхийн ажилтнууд бөгөөд бусад чиг үүргийн дотор шүүхийн ажилтнуудын үйл

⁵¹ Civil Execution Act (Act No. 4 of 1979)

https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3483#je_ch1at2

⁵² European Union's Justice Programme, Civil enforcement in the EU: a comparative overview, 2021 <https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>

ажиллагааг цар хүрээнд нь шалгаж, удирдан зохион байгуулж, шүүхийн ажилтнуудын эсрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээж, тодорхой шийтгэл ногдуулдаг. Түүнчлэн Засгийн газрын холбогдох нарийн бичгийн даргын санал болгосноор Хууль зүйн сайдын тушаалаар томилдог, Засгийн газрын нарийн бичгийн даргын өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, шүүхийн ажилтнуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээж, тодорхой шийтгэл ногдуулдаг нэг Бүсийн зохицуулагч нарийн бичгийн дарга аймаг бүрт байдаг.

Шүүхийн ажилтан нь шүүгчид олгогдсон эрх мэдлээс бусад тохиолдол дахь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хариуцдаг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүн саад учруулсан гэх зэрэг шаардлагатай тохиолдолд шүүхийн ажилтан төрийн хууль сахиулах байгууллагын албан тушаалтны тусламжтайгаар байранд нэвтэрч болдог.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч шүүхийн ажилтнуудын ажиллах цагийн хуваарь нь хязгаарлагдмал буюу үндсэн цаг Даваагаас Баасан гараг хүртэл 9 цагаас 14.30 цаг хүртэл; уян хатан цаг нь долоо хоногийн 37 1/2 цагийн үлдсэн хэсгийг бүрдүүлдэг ч Даваагаас Пүрэв гараг хүртэл өглөөний 7.30-18.00 цаг, баасан гаригийн 7.30-15.30 цагийн хооронд ажилладаг.⁵³ Зөвхөн онцгой тохиолдолд шөнийн цагаар болон амралтын өдөр, олон нийтийн амралтын өдрүүдээр ажилладаг. Мөн эвлэрүүлэн зуучлах, эвлэрүүлэх үйл ажиллагаа үзүүлэх ба ялангуяа хөдөлмөрийн эрх зүйн асуудлаар шүүхийн өмнөх шатанд энэ чиглэлээр ажилладаг.⁵⁴

(6) Швед улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

Швед улсын ШШГГ-т ажилладаг шийдвэр гүйцэтгэгч нар хуулийн мэргэжилтнүүд байдаг. 2016 оны 1333 §16 тушаалын дагуу тэд "улсын өрийг барагдуулах, дампуурлын хэрэгжилтийг хангах, хяналт тавихтай холбоотой журмын хуулийн хэрэгжилтийг баталгаажуулдаг". Энэхүү ажил нь төрийн болон хувийн хэвшлийн аль ч өрийн асуудлаар хуулийн дүгнэлт, шийдвэр гаргах, зөвлөлдөх санал асуулгын хариу, шүүхэд ашиглах мэдэгдэл, талуудын сонирхсон асуултад хариулах зэрэг орно. Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчидтэй илүү тулж ажиллаж, шийдвэр гаргахад нь тусалж, боловсролын үүрэг гүйцэтгэдэг төлөөлөгчдөд хууль эрх зүйн дэмжлэг үзүүлдэг. Тэдний ажилладаг хуулийн

⁵³ Wendy Kennett, Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge, 2021, page 480

⁵⁴ European Union's Justice Programme, Civil enforcement in the EU: a comparative overview, 2021 <https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>

салбарууд нь өргөн хүрээтэй буюу төлбөрийн чадваргүй байдал, өмчийн хууль гэх мэт тодорхой салбаруудаас гадна мэдээллийн хамгаалалт, хувийн нууцтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай болдог.

2016 оны 1333 тоот тушаалд зөвхөн Швед улсын иргэн л шийдвэр гүйцэтгэгч эсвэл дадлагажигч шийдвэр гүйцэтгэгч болно гэж заасан байдаг. Тус албанд өргөдөл гаргагч нь шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчтэй ижил шалгуурыг хангасан байх ёстой, эсвэл нотариатын албанд мэргэшсэн академик болон практик үе шатыг дүүргэсэн байх ёстой. Түүнчлэн, Үндэсний Шүүхийн Захиргаа нь тухайн тохиолдолд дадлага хийх шаардлагыг тогтооно.

ШШГГ-т мэргэжлийн ур чадвар шаардагдана. Хуульчдаас гадна мэдээллийн технологи, технологи, нийгмийн шинжлэх ухаан, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн хүмүүс ажилладаг. Төлбөр төлөгчтэй холбоотой харилцааг хариуцсан олон тооны захиргааны ажилтнууд, мөн бичиг баримтын үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон бусад өртэй холбоотой үүрэг хариуцлагыг хариуцдаг ажилтнууд байдаг. Хууль сахиулах ажиллагаатай харьцуулахад өөр мэргэжлийн боловсон хүчнийг үйлчилгээнд ажиллуулдаг. Үйлчилгээний ажлын үүрэг нь холбоо барих, төлбөр төлөгч ямар сонголт хийх, хэрхэн үргэлжлүүлэх талаар ойлгоход нь туслах явдал юм.⁵⁵

Швед улсын түүхэнд шийдвэр гүйцэтгэгч нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн нэг хэсэг байсан тул татвар болон бусад нийтийн эрх зүйн өрийг цуглуулах үүрэгтэй байсан. Иргэний болон арилжааны шүүхийн шийдвэрүүд болон хувийн эрх зүйн бусад шийдвэрийг гүйцэтгэх нь 17-р зууны үед нэмэлт зүйл байв. Гэсэн хэдий ч хувийн эрх зүйн зарчмуудтай харьцуулахад нийтийн эрх зүйн өрийг цуглуулахад арай өөр зарчимтай байдаг. Сүүлийн үед шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар аль зарчим, дүрмийг баримтлах ёстойг тодорхойлоход хүндрэлтэй байгаа бөгөөд эрх баригч хууль тогтоомжид төрийн өрийг нөхөн төлүүлэх талаар тусгайлан тодорхой зааснаас бусад тохиолдолд нийтийн болон хувийн эрх зүйн өр төлбөрт ижил зохицуулалт хэрэглэхийг зөвлөдөг.⁵⁶

Хуульд заасан тохиолдолд цагдаа нь шүүхийн ажилтанд албадан гүйцэтгэх, саад учруулсан байдлыг арилгахад шаардлагатай туслалцаа үзүүлэх ёстой. Шүүхийн шийдвэр

⁵⁵ Wendy Kennett, *Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge*, 2021, page 143

⁵⁶ Мөн тэнд

гүйцэтгэгчид саад учруулсан тохиолдолд цагдаагийн байгууллагын тусламжийг авдаг. Хуулийн дагуу гүйцэтгэх албан тушаалтан нь тухайн байранд ороход саад учруулсан, эсхүл зохисгүй үйлдэл гаргасан төлбөр төлөгч болон бусад этгээдийг нүүлгэн шилжүүлэхийг шаардаж болно. Мөн байшин руу нэвтрэхэд саад учруулсан этгээдэд торгууль ногдуулж болно.

Швед улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нар ажлын өдөр 6:00 – 21:00 хүртэл ажилладаг ба зөвхөн онц шаардлагатай тохиолдолд амралтын өдөр болон олон нийтийн амралтын өдрүүдээр ажилладаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ үзүүлдэггүй. Гэсэн хэдий ч төлбөр авагч болон төлбөр төлөгчийн хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийг дэмждэг. Ийм гэрээ нь нэхэмжлэлийг (мөнгөний болон бусад) шийдвэрлэх, гүйцэтгэх ажиллагааг хаахад хүргэдэг.⁵⁷

V. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

(1) Монгол Улсын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Монгол улсын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухайд төлбөрийг төлбөр төлөгч-иргэний өмчлөлийн эд хөрөнгө болон түүний банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө бусад хөрөнгөнөөс гаргуулах зохицуулалттай. Төлбөр төлөгч ямар эд хөрөнгөө төлбөр өгөх тухай хүсэлтээ тавих эрхтэй ба энэ нь шийдвэр гүйцэтгэхэд саад болохгүй бол хүсэлтийг харгалзан үздэг.

Эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, ББСБ дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө болон бусад үнэт зүйлээс, төлбөр төлөгч мөнгөн болон үнэт эд зүйл байхгүй, эсхүл төлбөр төлөгчөд хүрэлцэхгүй бол түүний өмчлөлийн бусад эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулна. Харин эд хөрөнгө төлбөр төлөгчөд хүрэлцэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулдаг.

⁵⁷ European Union's Justice Programme (2014-2020), Civil enforcement in the EU: a comparative overview, <https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах бол банк, ББСБ дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг шийдвэр гүйцэтгэгч банк, ББСБ-д хүргүүлэх бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг гаргаж 3 хоногийн дотор авагчид олгох буюу шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлдэг. Төсөвт байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй бол түүнийг санхүүжүүлдэг байгууллагад төлбөрийг гаргуулах мэдэгдлийг хүргүүлэх буюу дараагийн төсөвт нэмж тусгахыг шаардана. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс хассан буюу гүйлгээнд оруулахыг хязгаарласнаас бусад эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулах ба энэ тохиолдолд тухайн эд хөрөнгө хаана, юунд ашиглагдаж байгаа нь үл хамаарна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар гүйцэтгэх баримт бичиг, эсхүл түүний үндэслэл болсон шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай шүүх, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан; төлбөр авагч төлбөр авахаас татгалзаж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан; төлбөр төлөгч гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрөө бүрэн төлсөн; төлбөр төлөгч төлбөр авагчтай эвлэрч, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан; тодорхой үйлдэл, үйл ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг даалгасан шийдвэрийг биелүүлсэн; гүйцэтгэх баримт бичигт заасан тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болсон; төлбөр төлөгч-хуулийн этгээдэд холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэж хянан шийдвэрлэсэн, эсхүл татан буулгах ажиллагаа дуусгавар болоход гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахуйц хөрөнгө төлбөр төлөгчид байхгүй нь шүүхээр тогтоогдсон; төлбөр төлөгч-иргэн нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон, эсхүл төлбөр төлөгч, төлбөр авагч-хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан тохиолдолд гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих боломжгүй, эсхүл шаардлагыг эрх залгамжлагчаар гүйцэтгүүлэх боломжгүй; төлбөр төлөгч гүйцэтгэх баримт бичигт заасан тодорхой үйлдэл, үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй болсон нь тогтоогдсон тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дуусгавар болсонд тооцож, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг хаадаг.

(2) ХБНГУ-ын иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Иргэний процессын хуулийн 704-р зүйлд дурдсан эцсийн шийдвэр нь хамгийн чухал гүйцэтгэх шийдвэрүүдийн нэг юм: "Албадан гүйцэтгэх нь хууль ёсны хүчинтэй буюу түр

хугацаанд гүйцэтгэх боломжтой гэж мэдэгдсэн эцсийн шийдвэрээс хамаарна". ХБНГУ нь шийдвэр гүйцэтгэх процессыг Иргэний процессын хуулийн 704-793 дугаар зүйлүүдэд тодорхойлсон байдаг⁵⁸ Иргэний процессын хуульд заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэхдээ хариуцлагыг давхар хуваарилдаг. Нэг талаас, шийдвэр гүйцэтгэх шүүхүүд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг:⁵⁹

- Нэхэмжлэлийн болон бусад эд хөрөнгийн гүйцэтгэл (цалин/цалин, дансыг хаах, үнэт цаас битүүмжлэх гэх мэт)
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалах.

Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа нь хариуцагч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийн дагуу явуулах ажиллагаа бөгөөд хувийн эрх зүйн нэхэмжлэлийг нийтийн албадлагын дагуу хэрэгжүүлэхэд ашигладаг процесс юм.⁶⁰ Эцсийн гүйцэтгэлийн хувьд шүүхийн шийдвэр гарсны дараа эсвэл давж заалдах эрх дууссаны дараа хүчин төгөлдөр болно.

Төлбөр төлөх гэх мэт үүргийн гүйцэтгэлийг хариуцагчаас албадан гүйцэтгүүлэхийн тулд дараах арга хэмжээг авах боломжтой:

- Бараанаас суутгал хийх (Pfändung).
- Нэхэмжлэлийн болон хариуцагчийн эзэмшиж буй бусад эд хөрөнгийг суутгах (ялангуяа орлогыг суутгах)
- Төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулах (Vermögensauskunft)
- Үйл ажиллагаа явуулах буюу түүнээс татгалзуулах албадлагын арга хэмжээ (Zwangsmaßnahmen)
- Албадан худалдах (Zwangsversteigerung)
- Эрх шилжүүлэх (Zwangsverwaltung)

Мөнгөн төлбөрийн нэхэмжлэлтэй холбогдох шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлтэй холбоотой шүүхэд гаргасан өргөдөл нь хариуцагчийн нэхэмжлэлийн шаардлага, эрхийг

⁵⁸ The prerequisites for execution, Germany, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-1-prerequisites-execution-1>

⁵⁹ All-Russian State University of Justice, State and private enforcement systems: Comparative analysis and the best practices, ANDREAS ZEDEL, *High bailiff at the District Court of Eisenach/Thuringia, "The departmental responsibilities of the German bailiff - En transformation process from seizure and recovery to information gathering"*, Moscow, 2019, p564-568.

⁶⁰ How to enforce a court decision, Germany, https://e-justice.europa.eu/content_procedures_for_enforcing_a_judgment-52-de-en.do?member=1

тодорхойлох ёстой (жишээ нь банкны дансанд байршуулсан мөнгө эсвэл гуравдагч этгээдийн эсрэг нэхэмжлэл зэрэг). Эсхүл төлбөр авагч нь хариуцагчийн биет эд хөрөнгийн эсрэг шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхийн тулд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид (Gerichtsvollzieher) өргөдөл гаргаж болно. Мөн зээлдүүлэгч нь барьцааны зээл (Zwangshypothek) эсвэл үл хөдлөх хөрөнгийг албадан худалдах (Zwangsversteigerung) өргөдөл гаргах замаар төлбөр төлөгчийн үл хөдлөх хөрөнгийн эсрэг шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх боломжтой. Мөнгөн төлбөрийн шийдвэрээс бусад шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд өөр өөр дүрэм журам мөрдөгддөг.⁶¹

Хөдлөх хөрөнгийн хувьд гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн дагаж мөрдөх журмын дагуу хэрэгжинэ. Уг бүрэн эрхийн хүрээнд төлбөр авагчид ашигтай байж болох хөдлөх эд хөрөнгийг тодорхойлж, уг хөрөнгийг битүүмжлэх арга хэмжээ авах ёстой. Хуульд заасны дагуу төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн амьдралын наад захын хэрэгцээг хангахад шаардлагатай зарим хөрөнгийг албадлагын объект болгодоггүй.⁶²

Хариуцагч өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгөтэй бол уг нэхэмжлэлийг газрын бүртгэлд бүртгэх бөгөөд хариуцагч нь хөрөнгөө худалдахгүй байж болно. Дараагийн алхам нь эд хөрөнгийг битүүмжлэх, худалдах, эсвэл тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглаж байгаа түрээслэгч байгаа тохиолдолд шүүхийн шийдвэрээр битүүмжлэн авч болно.

Хурааж авах боломжгүй зүйлс "Unpfändbare Sachen" жагсаалтад орсон эд зүйлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хураан авах боломжгүй зохицуулалттай. Үүгээр хууль санаачлагч иргэдийн амьжиргааны доод түвшнийг баталгаажуулахын тулд өр төлбөртэй хүмүүсийг хамгаалахыг хичээсэн. Жишээлбэл, өр төлөгчийн орлого олох чадварыг баталгаажуулахын тулд түүний хөрөнгийн зарим хэсгийг хураан авч болдоггүй. Жишээ нь, бизнесийн бараа материалын ихэнх хэсгийг хураан авах боломжгүй. Хамгийн үр дүнтэй арга бол зээлдэгчийн дансыг хураах явдал юм.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаагүй тохиолдолд төлбөр авагчид өнгөрсөн жилийн санхүүгийн тайлан, түүний дотор бүх хөрөнгө, гүйлгээ, бусадтай холбоотой нэхэмжлэл гэх мэтийг ил болгохыг төлбөр төлөгчөөс шаардах

⁶¹Litigation and enforcement in Germany: overview, [https://content.next.westlaw.com/practical-law/document/I2ef128401ed511e38578f7ccc38dcbee/Litigation-and-enforcement-in-Germany-overview?viewType=FullText&ppcid=df4d45c30f1144d893ff704fab5d424d&originationContext=knowHow&transitionType=KnowHowItem&contextData=\(sc.Default\)&firstPage=true](https://content.next.westlaw.com/practical-law/document/I2ef128401ed511e38578f7ccc38dcbee/Litigation-and-enforcement-in-Germany-overview?viewType=FullText&ppcid=df4d45c30f1144d893ff704fab5d424d&originationContext=knowHow&transitionType=KnowHowItem&contextData=(sc.Default)&firstPage=true)

⁶² The Enforcement of a Title in Germany, https://www.mmrecht.com/claim_collection/enforcement_en.php (Сүүлд үзсэн: 2022.05.27)

сонголтыг өгдөг. Хэрэв шалгалтын явцад төлбөр авагчийн нэхэмжлэлийг хангахуйц хурааж авах боломжгүй хөрөнгө илэрсэн бол эдгээрийг хэрэгсэхгүй болгож болно. Дээрх санхүүгийн мэдээллээ задруулахаас татгалзвал шүүх өртэй хүмүүсийг баривчлах хүртэл шийдвэр гаргадаг.

Төлбөр авагч болон төлбөр төлөгчийн эрх зүйн хамгаалалт

а. Төлбөр авагчийн түр эрх зүйн хамгаалалт

Шүүхийн шийдвэр гарах хүртэл нэхэмжлэлийн эд хөрөнгийн нэхэмжлэлийг цагдан хорих, түр таслан сэргийлэх арга хэмжээ авах замаар баталгаажуулах боломжтой (Иргэний процессын хуулийн 916-945 дугаар зүйл).

Нэхэмжлэлийг баталгаажуулахын тулд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг. Иргэний баривчлах ажиллагаа (Иргэний процессын хуулийн 933-934-р зүйл) нь төлбөр төлөгчийг баривчлах боломжийг олгодог бөгөөд ингэснээр тэд эд хөрөнгөө төлбөр авагчийн ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулах боломжгүй болно. Үнэн хэрэгтээ цагдан хорихтой холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь төлбөрийн нэхэмжлэлийг хангахад чиглэгддэг бол түр зуурын захирамж нь бусад нэхэмжлэлд зориулагдсан байдаг.

Хохирлыг нөхөн төлөх үүрэг (Иргэний процессын хуулийн 945-р зүйл) нь цагдан хорих болон түр таслан сэргийлэх арга хэмжээний аль алинд нь хамаарна: "Хэрэв цагдан хорих, түр таслан сэргийлэх арга хэмжээ авах нь анхнаасаа үндэслэлгүй болох нь тогтоогдсон эсвэл уг арга хэмжээг хүчингүй болгох бол 926 (2) буюу 942 (3) зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тушаалыг хүлээн авсан тал нь уг арга хэмжээг хэрэгжүүлэх, эсхүл албадлагын арга хэмжээ авахаас зайлсхийх, эсхүл шийтгэл ногдуулах баталгаа гаргаж өгөх, тушаалыг хүчингүй болгох замаар өрсөлдөгчдөө учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй."

Иргэний процессын хуулийн 717(2) дугаар зүйлийн дагуу түр хугацаагаар хүчинтэй гэж зарласан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон эсвэл өөрчилсөн тохиолдолд төлбөр авагч төлбөр төлөгчид шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, эсхүл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг таслан зогсоохын тулд төлсөн төлбөрийн учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Өргөдөл гаргагч Иргэний процессын хуулийн 919-р зүйлд заасан шүүхэд өргөдөл гаргаснаар баривчлах ажиллагааг эхлүүлдэг: "Үндсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүх болон барьцаалагдсан зүйл эсвэл цагдан хоригдох этгээдийн харьяаллын дүүргийн шүүх аль аль нь цагдан хорих захирамж гаргах эрхтэй." 920-р зүйлийн дагуу өргөдөл гаргагч нь цагдан хорих үндэслэл, шаардлагыг гаргах ёстой бөгөөд өргөдлийг үндэслэлтэй гэж үзэхийн тулд шүүхэд нотлогдсон байх ёстой.

Цагдан хорих шаардлага нь Иргэний процессын хуулийн 916 (1) дугаар зүйлийн дагуу цагдан хорих нэхэмжлэлийг мөнгөн нэхэмжлэлийн үндэслэлээр эсвэл мөнгөн нэхэмжлэлд шилжүүлж болох нэхэмжлэлийн үндэслэлээр гаргах ёстой. Цагдан хорих үндэслэлийн тухайд хуулийн түр хамгаалалт нь ерөнхийдөө яаралтай байдаг тул өргөдөл гаргагч нь цагдан хорих шаардлага байгааг мөн батлах ёстой. Хуулиар суутгал хийх (917-р зүйл) болон иргэний баривчлах (Иргэний процессын хуулийн 918-р зүйл) хоёрыг ялгаж авч үздэг.

Иргэний баривчилгаа (918-р зүйл) нь эрх чөлөөг хязгаарлаж байгаа хэрэг учраас шийдвэр гүйцэтгэлийн эрсдэлийг арилгах өөр арга байхгүй тохиолдолд л урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой. Иймд баривчилгааг зөвхөн жишээ нь: Хариуцагч зугтах замаар үүргээс зайлсхийх эрсдэлтэй тохиолдолд буюу иргэний баривчлах ажиллагааг зөвхөн онцгой тохиолдолд л хэрэглэнэ.

Иргэний процессын 920-р зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу өргөдөл гаргагч нь нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж үзэхийн тулд шүүхэд нэхэмжлэл гаргах, цагдан хорих үндэслэлээ нотлох ёстой. Эрх бүхий шүүхэд гаргасан өргөдөл нь цагдан хорихтой холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүрдүүлдэг. Өргөдөл гаргагч нь анхан шатны нотлох баримтыг хангахын тулд "бүх нотлох баримтыг ашиглаж" болно. Өргөдлийг шүүх хуралдааны үндсэн дээр шийдвэрлэж, шүүх эцсийн шийдвэрийг гаргадаг. Хуулиар уг шүүхийн шийдвэрийг давж заалдах боломжтой (511-р зүйл). Битүүмжлэлийн тухайд, барьцаалах зорилгоор эд хөрөнгийг хураах (930-р зүйл), эсвэл барьцааг бүртгэдэг (932-р зүйл).⁶³

б. Төлбөр төлөгчийн эрх зүйн хамгаалалт

⁶³ The prerequisites for execution, Germany, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-1-prerequisites-execution-1>

Германы Иргэний процессын хуульд заасны дагуу анхан шатны шүүхийн шийдвэр нь зарчмын хувьд зөвхөн түр хугацаанд хүчинтэй байх бөгөөд хариуцагч нь барьцааны мөнгө өгснөөр гүйцэтгэлээс хэсэгчлэн зайлсхийх боломжтой. Энэ нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд гүйцэтгэх ажиллагааны улмаас хариуцагчид учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлөх үүрэгтэй.

Төлбөр авагч шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн давж заалдах эрхтэй боловч ийм давж заалдах гомдол нь шийдвэр гүйцэтгэлийг түдгэлзүүлэхгүй. Тиймээс давж заалдах гомдол гаргасан хэдий ч төлбөр авагч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлж, түр хугацаагаар үргэлжлүүлж болно. Шийдвэрийг талуудад хүргүүлснээс хойш нэг сарын дотор төлбөр төлөгч давж заалдах гомдол гаргах эрхтэй- хэрэв энэ хугацаанд давж заалдах гомдол гаргаагүй бол шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж, талууд заавал дагаж мөрдөх бөгөөд дахин шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түр хугацаагаар явуулахгүй болно.⁶⁴

Иргэний процессын хуулийн 717 дугаар зүйлд заасны дагуу түр хугацаанд хүчинтэй гэж зарласан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, өөрчлөх боломжтой. Үүний үр дүнд үүрэг гүйцэтгүүлэгч нь албадлагын гүйцэтгэлийг хүчингүй болгосон тохиолдолд "хохирлыг хариуцах" тул үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн эрсдэлд түр зуурын гүйцэтгэлийг гүйцэтгэж болно. 708, 709 дугаар зүйлүүдэд заасан бүх эцсийн шийдвэрүүд түр хугацаанд хүчинтэй гэж заасан. 708 дугаар зүйлийн дагуу барьцаа мөнгө шаардахгүйгээр түр гүйцэтгэх боломжтой гэж зарлах шийдвэрүүдийг жагсаасан байдаг бол 709 дүгээр зүйлд заасан шийдвэрүүд нь түр гүйцэтгэхийн тулд төлбөр авагчаас барьцаа шаарддаг.⁶⁵

Хэрэв төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж давж заалдвал Иргэний процессын хуулийн 719-р зүйлд шүүх төлбөр төлөгчийн хүсэлтээр, тухайлбал, баталгаа гаргаж өгөхгүйгээр гүйцэтгэх ажиллагааг түр түдгэлзүүлэхээр шийдвэрлэж болно гэж заасан. Шийдвэр нь шүүхийн үзэмжээр; Шүүхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн бол ихэнх тохиолдолд зөвхөн төлбөр төлөгч баталгаа гаргаж байж түдгэлзүүлдэг.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эсрэг эрх зүйн арга хэмжээ буюу албадан гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох, хязгаарлах нөхцөлүүдийг Иргэний процессын хуулийн 766, 767, 771 дүгээр зүйлд байдаг. Эдгээр нь дараах байдалтай байна. Энэхүү зохицуулалтын

⁶⁴ Мөн тэнд,

⁶⁵ The prerequisites for execution, Germany, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-1-prerequisites-execution-1>

зорилго нь материаллаг үндэслэл өөрчлөгдсөний улмаас албадан гүйцэтгэлийг арилгахад оршино. Иргэний процессын хуулийн 771 дүгээр зүйлд зааснаар шүүх ажиллагаанд урьд өмнө нь оролцоогүй этгээдэд (гуравдагч этгээд) битүүмжлэгдсэн эд хөрөнгө нь төлбөр төлөгчийнх биш, харин гуравдагч этгээд өөрийнх нь гэсэн үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эсэргүүцэх эрхтэй.⁶⁶

(3) БНСУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

БНСУ-ын Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн хэлбэр нь:

1. Албадан гүйцэтгэх ажиллагаа;
2. Дуудлага худалдаа;
3. Битүүмжлэг зэрэг юм.

Ийнхүү хамгийн эхний төрөл болох албадан гүйцэтгэх ажиллагааг дэлгэрүүлэн авч үзье.

а. Эд хөрөнгийн мэдүүлэг авахтай холбоотой албадан гүйцэтгэх ажиллагаа

Төлбөр төлөгч төлбөрийг барагдуулах чадвартай байгаа боловч барагдуулахгүй байх тохиолдолд төлбөр төлөгчийн эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан бүртгэж, эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарладаг тогтолцоог эд хөрөнгийн мэдүүлэг авахтай холбоотой албадан гүйцэтгэх ажиллагааг хийдэг байна.

Төлбөр авагч дээр дурдсан эд хөрөнгийн бүртгэлийг хийлгэх талаар шүүхэд өргөдөл гаргах бөгөөд иргэний шүүх үүнийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Төлбөр төлөгч шүүхийн шийдвэр гармагц өөрийн эд хөрөнгийн бүртгэлийн жагсаалтыг гарган шүүхэд өөрийн биеэр ирэх үүрэг хүлээх ба шүүхэд биеэр ирээгүй эсхүл эд хөрөнгөө нуун далдалж, худал мэдүүлэх тохиолдолд гурваас доош жилийн хорих ял эсхүл таваас доош вонын торгууль оногдуулна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу төлбөр төлөгчийн “хөрөнгө бүртгэл” зайлшгүй шаардлагатай гэж үзвэл иргэний шүүх “хөрөнгийн бүртгэл”-ийг гаргаж өгөхийг шаардах бөгөөд шаардах хуудсыг төлбөр авагч

⁶⁶ Enforcement of Judgments Germany, <https://practiceguides.chambers.com/practice-guides/comparison/683/7154/11684-11686-11694-11701>

болон төлбөр төлөгчид илгээнэ. Төлбөр төлөгч уг шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд уг хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу баривчлах арга хэмжээ авна.

Эд хөрөнгийн бүртгэл явуулах тухай шүүхийн шийдвэрт төлбөр төлөгч гомдол гаргаагүй бол шүүх хөрөнгийн бүртгэлийг хянах шүүх хурлын товийг гарган төлбөр төлөгчийг оролцуулна. Хэрэв төлбөр төлөгч энэхүү шүүхийн шийдвэрт гомдол гаргах бол 7 хоногийн дотор шүүхэд өргөдөл гаргаж болох бөгөөд шүүх өргөдлийг хүлээн авбал уг шийдвэрийг хүчингүй болгоно. Харин эд хөрөнгийн бүртгэлд оруулах эд хөрөнгийн хүрээг дээд шүүхийн дүрмийн дагуу тогтооно.

Мөн төлбөр авагчийн өргөдлийн дагуу шүүх нь төрийн байгууллага, банк санхүүгийн байгууллага, нийгэмлэг гэх мэт хуулийн этгээдээс төлбөр төлөгчийн эд хөрөнгийн бүртгэлийн лавлагааг дараах тохиолдолд гаргуулж болно. Үүнд:

- Эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн хөрөнгө нь төлбөр авагчийн нэхэмжлэлийг барагдуулахад хангалттай бус;
- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт заасны дагуу гаргуулах.

Энэ тохиолдолд төлбөр авагч өөрөө холбогдох хуулийн этгээдийн нэрсийг гаргаж өгөх бөгөөд эд хөрөнгийн бүртгэлийн лавлагааны зардлыг хариуцна. Ийнхүү нэмэлтээр илэрсэн эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр төлөгчийн эд хөрөнгийн бүртгэлд оруулна.

б. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой албадан гүйцэтгэх ажиллагаа

Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой албадан гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн өргөдлийн дагуу шүүх гүйцэтгэнэ (ИШГАтХ-ийн 78 дугаар зүйлийн 78.1). Үл хөдлөх эд хөрөнгийн албадан гүйцэтгэхдээ албадан дуудлага худалдаа, зохицуулах гэсэн үндсэн арга байна.

Үл хөдлөх хөрөнгийг зохицуулах арга нь дуудлага худалдаанаас ялгаатай бөгөөд төлбөр төлөгчийн битүүмжлэгдсэн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг хязгаарладаггүйгээрээ онцлог байна. Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийг шүүхээс битүүмжилж, тухайн эд хөрөнгийн зохицуулагчийг томилсноор тухайн үл хөдлөх эд хөрөнгийг захиран зохицуулж ашиг гаргаснаар нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг барагдуулах арга юм.

Ийнхүү төлбөр авагч нь дээрх хоёр аргаас нэгийг сонгох эсвэл хоёуланг нь ч сонгож албадан гүйцэтгэх ажиллагааг явуулж болно. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тухайн үл хөдлөх эд хөрөнгө байгаа газрын харьяа шүүх гүйцэтгэнэ (ИШГАТХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.1).

Албадан дуудлага худалдаа зохион байгуулахын тулд төлбөр авагч, төлбөр төлөгч болон шүүхийн тэмдэглэгээ, үл хөдлөх эд хөрөнгийн тэмдэглэгээ, дуудлага худалдаа зохион байгуулах эрх зүйн зохицуулалт гэх мэтийг тэмдэглэх шаардлагатай. Дуудлага худалдааг зохион байгуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь үл хөдлөх эд хөрөнгөд үзлэг хийхийн тулд тухайн байгууламжид нэвтрэн орох, төлбөр төлөгч болон байгууламжийн эзэмшигч болох гуравдагч этгээдээс асуулт асуух, холбогдох баримт бичгийг шаардах эрхтэй (ИШГАТХ-ийн 82 дугаар зүйлийн 82.1). Мөн шаардлагатай тохиолдолд барилга, байгууламжид хүчээр буюу хаалгыг нь эвдэн орж болно (ИШГАТХ-ийн 82 дугаар зүйлийн 82.2). Дуудлага худалдаа хийх шүүхийн тогтоол гармагц үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилнэ. Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх нь төлбөр төлөгч тухайн үл хөдлөх эд хөрөнгийг арчлах, хэрэглэхэд хязгаарлалт болохгүй (ИШГАТХ-ийн 83 дугаар зүйлийн 83.2) бөгөөд шүүх өөрийн эрх мэдлийн хүрээнд эсхүл эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу тухайн үл хөдлөх эд хөрөнгөд эвдрэл, гэмтэл гаргахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авч болно. Албадан дуудлага худалдаа хийх аргыг тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх шүүх тогтоно.

в. Усан тээврийн хэрэгсэлтэй холбоотой албадан гүйцэтгэх ажиллагаа

Улсын бүртгэлд бүртгэлтэй усан тээврийн хэрэгсэлтэй холбоотой албадан гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэхдээ үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулах журмыг мөрдөх бөгөөд усан тээврийн хэрэгсэл байгаа газрын шүүх харьяалан гүйцэтгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь усан тээврийн хэрэгслийн харьяалал болон холбогдох бусад баримтыг усан тээврийн хэрэгслийн жолоочоос авах, тухайн тээврийн хэрэгслийг харьяа нутаг дэвсгэрээс гаргахгүй байх шаардлагыг тавих үүрэгтэй байна. Харин аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, шаардлагатай бусад тохиолдолд төлбөр төлөгчийн хүсэлтээр тухайн тээврийн хэрэгслийг ашиглахыг зөвшөөрч болно. Энэ тохиолдолд нэхэмжлэгчийн зөвшөөрлийг авсан байх шаардлагатай юм.

г. Хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой албадан гүйцэтгэх ажиллагаа

Хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой албадан гүйцэтгэх ажиллагааны үндсэн арга нь тухайн эд хөрөнгийг битүүмжлэх юм. Зарчмын хувьд хөдлөх хөрөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч өөрөө битүүмжлэн хадгалах ёстой боловч тухайн хөдлөх хөрөнгийг зөөж тээвэрлэхэд бэрхшээлтэй тохиолдолд төлбөр авагчийн зөвшөөрөлгүйгээр төлбөр төлөгч уг хөдлөх хөрөнгийг ашиглах, хэрэглэх боломжгүйгээр төлбөр авагчтай тохиролцсоны үндсэн дээр төлбөр төлөгчид хадгалуулж болно гэж хуульчилсан байна. Гэхдээ бодит байдал дээр битүүмжилсэн хөрөнгийг төлбөр авагч, төлбөр төлөгч хадгалах тохиолдол их байна⁶⁷ Энэ хэдийгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн зөвшөөрлөөр хөдлөх хөрөнгийг төлбөр төлөгчид хадгалуулж байгаа тохиолдол боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хөдлөх эд хөрөнгийг хадгалах хамгаалах үүргээс чөлөөлөгдөхгүй юм.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуульд хөдлөх эд хөрөнгийг битүүмжилж болох хөдлөх хөрөнгө, битүүмжлэхийг хориглосон хөрөнгө хэмээн хоёр хуваан зохицуулжээ. Битүүмжилж болох хөдлөх хөрөнгө гэдэгт газрын бүртгэлд оруулах боломжгүй газар дээр байгаа хөрөнгө, газраас салгахгүйгээр 1 сарын дотор хураах боломжтой ургамал, мөнгөн дэвсгэрт багтах бөгөөд битүүмжлэхийг хориглосон хөрөнгө гэдэгт хариуцагчийн ахуй амьдралд нэн шаардлагатай хэрэглээний эд зүйлс, тариачны тариа тарих, загас барих, оршуулганд хэрэглэх эд зүйлс гэх мэт багтана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэн дуудлага худалдаагаар борлуулах бөгөөд өндөр үнэтэй хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулахын тулд хөрөнгө үнэлгээний байгууллагад хандан үнэлгээ хийлгэнэ. Ийнхүү хөдлөх хөрөнгийг битүүмжилснээс хойш 7 хоногийн дотор дуудлага худалдааг зохион байгуулах ёстой боловч битүүмжилсэн эд зүйлс муудах, хугацаа хэтэрсэн тохиолдолд эд хөрөнгийн үнэ унах магадлалтай бол 7 хоногоос өмнө дуудлага худалдааг зохион байгуулж болно (ИШГАтХ-ийн 202 дугаар зүйл).

Дуудлага худалдааг зохион байгуулахдаа тухайн хөдлөх хөрөнгө байгаа нутаг дэвсгэр дээр зохион байгуулах бөгөөд төлбөр авагч, төлбөр төлөгч нар дуудлага худалдаа зохион байгуулах газрыг харилцан тохирсон тохиолдолд тэдний тогтсон газарт зохион байгуулж болно. Үүнээс гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэгч мөнгөн тэмдэгт, хувьцаа, чек гэх мэтийг битүүмжлэн төлбөр авагчийн нэхэмжлэлийг хангах ба төлбөр төлөгч цалин,

⁶⁷ 허승, 유체동산의 가압집행에 있어 집행관이 부담하는 주의의무에 대한 검토, 한국민사집행법학회, 2018, 195 면.

тэтгэвэр, эмчилгээний төлбөр, тэтгэмжийг битүүмжлэхийг хориглодог байна (ИШГАТХ-ийн 246 дугаар зүйл).

Дуудлага худалдаа:

Барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгийг дуудлага худалдаанд оруулахын тулд барьцаанд байгаа нотлох баримтыг бүрдүүлэх, барьцааны эрхээ шилжүүлсэн бол үүнийг нотлох баримтыг шүүхэд шилжүүлнэ.

Дуудлага худалдаа зохион байгуулах шүүх дараах тохиолдолд дуудлага худалдааг зогсооно. Үүнд:

- Барьцааны хүчинтэй хугацаа дууссан;
- Шүүхээс барьцааг хүчингүй болгосон;
- Барьцаалах эрхгүй, эрх нь дууссан тухай шүүхийн тогтоол гарсан зэрэг юм.

Энэхүү дуудлага худалдааг тус хуулийн 189 дүгээр зүйлээс 222 дугаар зүйл, 265 дугаар зүйл, 266 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

Битүүмжлэх:

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх нэмэлт арга хэмжээний нэг арга бол битүүмжлэх арга юм. Битүүмжлэх нь хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулан мөнгөн эргэлтийг үүсгэснээр нэхэмжлэл барагдуулах хэлбэр юм. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэл гарсан эсхүл хэрэгжүүлэх боломжгүй эрсдэл байвал эд хөрөнгийг битүүмжилнэ (ИШГАТХ-ийн 276 зугаар зүйл). Эд хөрөнгийг битүүмжлэх тухай шүүхийн үйл ажиллагааг төлбөр төлөгчид мэдэгдсэнээс хойш 2 долоо хоногийн дараа хийх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь тухайн шийдвэрийг гаргасан шүүх хариуцан зохион байгуулдаг.

(4) Япон улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Япон улсын хувьд төлбөр төлөгч нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан үүргээ сайн дураар биелүүлээгүй тохиолдолд төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай хүсэлт гаргадаг. “Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай

хууль” хуульд шүүхийн шийдвэр биелэлтийг дараах үндсэн 4 төрөлд хувааж авч үзсэн байна.⁶⁸

- “Албадан гүйцэтгэх” “Compulsory Execution” - шүүхийн шийдвэр болон бусад үүргийн үндсэн дээр иргэний нэхэмжлэлийг албадан хэрэгжүүлэх.
- Барьцааны хөрөнгийг албадан гаргуулах” “Exercise of a Security Interest” – Барьцааны хөрөнгийг бэлэн мөнгө болгон хөрвүүлэх.
- "Дуудлага худалдаа" “External Auction” - Иргэний хууль, Арилжааны хууль гэх мэт зүйл заалтын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа.
- "Өөрт байгаа эд хөрөнгийг дэлгэн, илчлэх" “Disclosure of Property” - Хариуцагчийн эд хөрөнгийг ил болгох.

Эдгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шинж чанарын хувьд өөр боловч шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтнуудын хувьд хууль ёсны эрх, ашиг сонирхлыг албадан хэрэгжүүлдэг үндэсний хэмжээний гүйцэтгэх ажиллагаа хэмээн Проф. Masami Shimomura судалгаандаа онцолжээ⁶⁹. Тэр дундаа (а) "Албадан гүйцэтгэх" ба (б) "Е Барьцааны хөрөнгийг албадан гаргуулах" нь бусад ажиллагаанаас илүү чухал буюу иргэний нэхэмжлэлийг биелүүлэх эцсийн арга хэмжээ юм. Эдгээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хангалтгүй бол иргэдийн шүүхийн шийдвэрт итгэх итгэл алдарч, нийгмийн хэв журмыг сахиулахад хүндрэл учруулж болзошгүй тул иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөв, шуурхай гүйцэтгэх нь нийгмийн чухал шаардлагатай тухай Профессор Масами Шимомура судалгаандаа цохон тэмдэглэсэн байна⁷⁰.

а. Албадан гүйцэтгэх ажиллагаа

Төлбөр төлөгчийн өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгө, нэхэмжлэлийн шаардлагыг албадан хурааж, худалдах, худалдсанаас олсон орлогыг үүрэг гүйцэтгүүлэгчид төлүүлэх замаар нэхэмжлэлийг албадан гаргуулан авах ажиллагааг мөнгөн нэхэмжлэлийн шаардлагыг албадан гүйцэтгэх ажиллагаа гэнэ. Япон улсын Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд албадан гүйцэтгэх ажиллагааг дараах төрөлд хуваан авч үздэг байна. Үүнд:

⁶⁸ Suk, K. H. (2018). Recognition and Enforcement of Judgments Between China, Japan and South Korea in the New Era: South Korean Law Perspective. *Frontiers of Law in China*, 13(2), 171–201. <https://doi.org/10.3868/s050-007-018-0013-7>

⁶⁹ Shimomura, M. (2010). Civil Execution System and Insolvency System. Available at SSRN 1612704.

⁷⁰ Shimomura, M. (2010). Civil Execution System and Insolvency System. Available at SSRN 1612704.

1. Үл хөдлөх хөрөнгийн эсрэг албадан гүйцэтгэх ажиллагаа
2. Хөлөг онгоц, үлэмж хэмжээний контейнэрийн эсрэг албадан гүйцэтгэх ажиллагаа
3. Хөдлөх эд хөрөнгийн эсрэг албадан гүйцэтгэх ажиллагаа
4. Нэхэмжлэл болон бусад эд хөрөнгийн эрхийн эсрэг албадан гүйцэтгэх ажиллагаа
5. Мөнгө төлөх зориулалтгүй нэхэмжлэлийг албадан гүйцэтгэх ажиллагаа

Үл хөдлөх эд хөрөнгө албадан гүйцэтгэх ажиллагааг шүүх, хөдлөх эд хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч тус тус гүйцэтгэдэг. Харин үл хөдлөх эд хөрөнгийн эсрэг албадан гүйцэтгэх ажиллагааны тухайд тухайн үл хөдлөх эд хөрөнгийг худалдахаас өмнө тухайн үл хөдлөх хөрөнгийн өнөөгийн нөхцөл байдлыг судалж, мөрдөн байцаалтын ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаныхан гүйцэтгэдэг бөгөөд үүнийг мөнгөн бус нэхэмжлэлийг албадан гүйцэтгэх ажиллагаа гэнэ.

Үл хөдлөх хөрөнгийг шууд болон шууд бус албадан гүйцэтгэх гэсэн хоёр өөр аргаар гүйцэтгэж болно. Шууд албадан гүйцэтгэх тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэгчийг холбогдох үл хөдлөх хөрөнгөөс биеэр албадан гаргана. Шууд бус албадан гүйцэтгэх ажиллагаа гэдэг нь шүүхээс үүрэг гүйцэтгэгчийг үүргээ биелүүлээгүйн улмаас мөнгөн шийтгэл оногдуулж үүргээ биелүүлэхийг шаардах ажиллагааг хэлнэ.

Албадан гүйцэтгэх ажиллагааны явцад шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь иргэний нэхэмжлэлийн шаардлагыг “Үүргийн бичиг” “Title of Obligation” -т үндэслэн албадан гаргадаг. Энэ нь үндсэндээ үүргийн биелэлтийг хангах хүчин төгөлдөр шүүхийн эцсийн шийдвэр юм. Албадан гүйцэтгэх ажиллагааг тодорхой хэмжээний мөнгө төлүүлэх иргэний нэхэмжлэлд чиглэсэн мөнгөн гүйцэтгэл, бусад гүйцэтгэлд чиглэсэн мөнгөн бус гүйцэтгэл гэж ангилдаг. Мөнгөн гүйцэтгэл нь хариуцагч сайн дураар төлөх хэлбэрийг бий болгож, улмаар хүссэн хүсээгүй түүний эзэмшиж байгаа эд хөрөнгийг ихэвчлэн худалдах замаар мөнгөн хэлбэрт оруулан хувиргадаг бөгөөд “тухайлсан эд хөрөнгийг битүүмжлэх” → “Хөрвөх” → “Нэхэмжлэлийн шаардлагыг хангах” зарчмаар үйл ажиллагаа явагддаг байна. Энэхүү үйл ажиллагааны алхам тутамд шийдвэр гүйцэтгэгч оролцож явдаг онцлогтой.

б. Дуудлага худалдаа

Шийдвэр гүйцэтгэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн барьцаанд үлдээсэн үл хөдлөх хөрөнгө зэрэг эд хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах ажиллагааг баталгаар хангах дуудлага худалдаа (auction for the exercise of a security interest)

гэх бөгөөд энэхүү дуудлага худалдааны журам нь мөнгөн нэхэмжлэлийг албадан гүйцэтгэх ажиллагаатай адил явагдана.

в. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой албадан гүйцэтгэх ажиллагаа (Civil provisional remedies)

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар эд хөрөнгө захиран зарцуулахыг түр хугацаагаар хориглох, эрхийн хэрэгжилтийг хангах үүднээс талуудын урьдчилсан байр суурийг тодорхойлох ажиллагааг civil provisional remedies гэнэ. Ийм ажиллагаа явуулахгүй бол хариуцагч нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эд хөрөнгөгүй болсон тохиолдолд нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх боломжгүй болох эрсдэл үүсдэг. Жишээлбэл, хариуцагч бүх эд хөрөнгөө зарсан, үрэгдүүлсэн бол нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх боломжгүй болж, нэхэмжлэгч холбогдох үл хөдлөх хөрөнгийг өмчлөхөө больсон бол нэхэмжлэгч албадан гаргуулж авах эрхгүй болно гэсэн үг. Энэхүү нөхцөл байдал нь нэхэмжлэгчдэд хүнд байдал үүсгэдэг тул энэхүү байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд шүүх шийдвэр гүйцэтгэгчийн хөрөнгийг ирээдүйд албадан гүйцэтгэх боломжтой болгох зорилгоор түр битүүмжлэх, эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг түр хугацаагаар хориглох, үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийг үндэслэн түр мөнгөн төлбөрөөр хийх арга хэмжээг урьдчилсан байдлаар авах зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

г. Хариуцагч эд хөрөнгөө дэлгэн, илчлэх тухай зохицуулалт

2001 оноос өмнө Японд Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эд хөрөнгийг ил болгох журмын талаар ямар ч заалт тусгаагүй байсан. Төлбөр авагч нь хариуцагчийн эд хөрөнгийн талаар мэдээлэлгүй, эсхүл хариуцагч эд хөрөнгөө нуун дарагдуулсан тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч шүүхээр баталгаажуулсан нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх боломжгүй болно. Улмаар 2001 онд Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эд хөрөнгө ил тод болгох журмыг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь нэхэмжлэгч хариуцагчийн эд хөрөнгийн талаарх мэдээллийг хариуцагчийн шүүхэд гаргасан мэдүүлгээр олж авах боломжийг олгосон.⁷¹ Гэвч хариуцагч нь өөрийн өмч хөрөнгөө ил болгох үүргээ биелүүлээгүйн улмаас оногдуулах шийтгэл харьцангуй бага байсан тул эд хөрөнгө ил болгох журмыг ерөнхийд нь хүчингүйд тооцсон. 2019 оны тавдугаар сарын 10-ны өдөр Эд

⁷¹<https://practiceguides.chambers.com/practice-guides/enforcement-of-judgments-2021/japan/trends-and-developments>

хөрөнгө ил болгох журмыг илүү үр дүнтэй болгох үүднээс Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталсан бөгөөд Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан үндсэн заалтууд орсон бөгөөд тухайлбал,

Иргэний шийдвэр гүйцэтгэх хуулийн дагуу эд хөрөнгө ил болгох журам нь хариуцагчийн эд хөрөнгийн талаарх мэдээллийг хариуцагчаас шууд авах зорилготой. Японд өмгөөлөгч бүр өөрийн харьяалагддаг хуульчдын холбооноос төрийн байгууллага, компани гэх мэт холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас тодорхой мэдээлэл цуглуулахыг хүсэлт гаргаж (Хуульчдын холбоонд мэдээлэл авах хүсэлт) бөгөөд Өмгөөлөгчдийн холбоо нь энэ хэрэгтэй холбоотой эсэх, шаардлагатай эсэхийг нягталж үзээд, өмгөөлөгчид мэдээлэл цуглуулахыг зөвшөөрсний дараа холбогдох байгууллагуудаас тодорхой мэдээлэл ирүүлэхийг шаардах эрх үүсдэг байна. Нэхэмжлэгч нь хариуцагчийн эд хөрөнгийн талаарх мэдээллийг дээрх гуравдагч этгээдээс авч болох бөгөөд энэ систем нь зөвхөн хуульчдын холбооноос мэдээлэл авах хүсэлт гаргахад л хязгаарлагддаг боловч зарим санхүүгийн байгууллагууд ийм мэдээллийг задруулахаас татгалздаг тул үр өгөөж багатай байсан тул нэмэлтээр нэхэмжлэгч нь хариуцагчийн эд хөрөнгийн талаарх мэдээллийг гуравдагч этгээдээс задруулахыг албадуулсан шүүхийн захирамж гаргуулахыг шаардаж болохоор тусгасан байна. Тухайлбал, нэхэмжлэгч нь зээлийн хоршоо, банк, хөдөө аж ахуйн хоршоо, гэх мэт санхүүгийн байгууллагаас шийдвэр гүйцэтгэгчийн хадгаламж, хадгаламж, бүртгэлтэй хувьцаа, засгийн газрын бонд гэх мэт мэдээллийг авч болохоор заасан байна (207 дугаар зүйл). Мөн нэхэмжлэгч шийдвэр гүйцэтгэгчийн дансаа байршуулсан банкны нэрийг мэддэг бол хэдий ч тухайн хариуцагчийн эд хөрөнгө, хадгаламж байгаа эсэх, байршуулсан дүн, дансны төрөл гэх мэт мэдээллийг авах боломжтой. Авсан мэдээлэлд үндэслэн нэхэмжлэгч нь хариуцагчийн эд хөрөнгийн эсрэг нэхэмжлэлийг шүүхийн дэмжлэгтэйгээр албадан гүйцэтгүүлэх боломжтой. Нэхэмжлэгч нь хариуцагчийн газар, барилгын талаарх мэдээллийг Бүртгэлийн газраас (205-р зүйл), хариуцагчийн цалингийн мэдээллийг Хотын захиргаа, Японы Тэтгэврийн алба гэх мэт (206-р зүйл) авах боломжтой. Тус хуулийн 213-р зүйлд зааснаар төлбөр төлөгч санаатайгаар эд хөрөнгө, өмчөө нуун дарагдуулсан тохиолдолд 6 сар хүртэлх хорих ял оногдуулахаар заасан байна. Иймд төлбөр авагч нь Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхийн албадан гүйцэтгэх шийдвэрийн дагуу төлбөр төлөгчийн эд хөрөнгийн талаарх мэдээллийг олж авах боломж бүрдүүлсэн бөгөөд шүүхийн шийдвэрээр санхүүгийн байгууллагаас авсан мэдээлэлд үндэслэн албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлдэг онцлогтой байна.

(5) Испани улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хүссэн тал төлбөр төлөгчийн өмчлөлд ямар хөрөнгө байгааг мэдэхгүй бол шүүхээс лавлагаа гаргуулж болно. Эдгээрийг бүртгэгч шүүхээс шууд эсвэл эрх бүхий байгууллагад хүсэлт гаргах замаар гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч, доор жагсаасан цалин, орлого, түүний нэмэгдэлд хэд хэдэн хязгаарлалт байдаг. Тэтгэмж төлөх захирамжаас үүдэн гарах шийдвэр гүйцэтгэл (хамаатан садны хоорондын тэтгэлэг, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг нь хүүхдэд төлөх тэтгэлэгтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдсон) онцгой тохиолдол бөгөөд эдгээр тохиолдолд шийдвэр гүйцэтгэл нь хуулиар тогтоосон хэмжээнээс хамаарахгүй; оронд нь шүүх төлөх хэмжээг тогтоодог (Иргэний процессын хуулийн 608-р зүйл).⁷²

Хураан авах боломжгүй эд хөрөнгийн тухайд Иргэний процессын хуулийн 605-р зүйлд дараах зүйлийг заасан байдаг:

605 дугаар зүйл. Халдаж боломжгүй хөрөнгө. Дараах хөрөнгийг ямар ч тохиолдолд хураан авч болохгүй.

- Халдаж болохгүй гэж зарласан хөрөнгө.
- Үндсэн эрхээс салгаж авч үл болох туслах эрх.
- Өөрт ямар ч үнэ цэнэгүй хөрөнгө.
- Хуулийн заалтаар өмчлөх боломжгүй гэж тодорхой заасан.

606 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрээр төлбөр төлөгчөөс хураан авч болохгүй хөрөнгө.

- Зайлшгүй шаардлагатай гэрийн тавилга, гэр ахуйн эд зүйлс, түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа этгээд, түүний гэр бүлийнхний хувцас. Шүүхийн үзэж байгаагаар шүүхийн шийдвэрийн хариуцагч болон түүний асрамжид байгаа хүмүүс зохистой нэр төртэй амьдрахад зайлшгүй шаардлагатай хоол хүнс, түлш болон бусад зүйлс.

⁷² How to enforce a court decision, Spain https://e-justice.europa.eu/52/EN/how_to_enforce_a_court_decision?SPAIN&member=1

- Шүүхийн шийдвэрийн төлбөр төлөгчид өөрийн мэргэжил, урлаг, худалдаа эрхлэхэд шаардлагатай ном, хэрэглүүр, тэдгээрийн үнэ цэнэ нь нэхэмжилсэн өрийн хэмжээтэй пропорциональ бус.
- Хууль ёсоор бүртгэгдсэн шашны үйл ажиллагаанд ашигладаг ариун нандин эд зүйлс.
- Хуулиар хураан авах боломжгүй гэж тодорхой заасан дүн.
- Испани улсаас соёрхон баталсан Гэрээгээр хураан авах боломжгүй гэж зарласан хөрөнгө, дүн.

607 дугаар зүйл. Цалин, тэтгэвэр

1.Хөдөлмөрийн хөлс, хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, тэтгэмж, түүнтэй адилтгах хэмжээний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоосон хэмжээнээс доогуур байгаа мөнгийг хураахаас чөлөөлнө.

2.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс өндөр цалин, хөлс, урамшуулал, тэтгэврийг дараах хуваарийн дагуу хураан авч болно.

- Эхний нэмэгдэл бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 30 хувь.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэмэгдэл бол 50 хувь.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэмэгдэл бол 60 хувь.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэмэгдэл бол 75 хувь.
- Дээрх хэмжээнээс хэтэрсэн аливаа дүнгийн хувьд 90%.

3. Шийдвэр гаргуулж байгаа тал нэгээс дээш цалин, хөлс авсан бол бүгдийг нь нийлүүлж, үл хамаарах хэсгийг нэг удаа хасна. Гэрлэгчдийн хувьд тусдаа эдлэн газар тогтоогоогүй бөгөөд үүнийг нотлох баримтаа шүүх хуралдааны нарийн бичгийн даргад ирүүлээгүй тохиолдолд эхнэр, нөхөр хоёрын цалин, орлого, тэтгэвэр, тэтгэмж, түүнтэй адилтгах мөнгийг нэгтгэнэ.

5. Хэрэв цалин, орлого, тэтгэвэр, урамшуулалд татвар, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн дагуу нийтийн шинж чанартай байнгын болон түр зуурын суутгалын дарамт

үүссэн бол эдгээр суутгалын дараа төлбөр төлөгчөөс авсан цэвэр дүн нь хурааж авах дүнг тодорхойлох үндэслэл болно.

6. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа мэргэжлийн болон арилжааны үйл ажиллагаанаас олсон орлогод энэ зүйлийн өмнөх заалтууд нэгэн адил хамаарна.

7. Энэ заалтын дагуу хураан авсан мөнгийг битүүмжлэлийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Шүүхийн нарийн бичгийн дарга зөвшөөрсөн тохиолдолд тухайн талын өмнө нь тогтоосон дансанд шууд шилжүүлж болно.

Энэ тохиолдолд хураан авах, дараа нь шилжүүлэх үйл ажиллагаа явуулж буй хүн, байгууллага, түүнчлэн шийдвэр гүйцэтгэхийг хүссэн тал аль аль нь нэхэмжлэлийн шаардлагыг эс тооцвол илгээсэн болон хүлээн авсан дүнгийн талаар шүүх хуралдааны нарийн бичгийн даргад гурван сар тутамд мэдэгдэх ёстой. Өр төлбөрийг бүрэн барагдуулсан гэж үзэж, битүүмжлэлийг хүчингүйд тооцсон, эсхүл заасны дагуу шилжүүлгийг хийгээгүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шаардаж байгаа тал шүүх хуралдааны нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.⁷³

Хөдлөх эд хөрөнгийг худалдах буюу дуудлага худалдаанд оруулахдаа Испанид хөдлөх эд хөрөнгийг нийтийн худалдаа, бараа бүтээгдэхүүний зах зээл дээр эсвэл талуудын тохиролцсон борлуулалтаар хийж гүйцэтгэдэг. Худалдах ажиллагаа дуусаж, орлогыг хуваарилснаар хөдлөх хөрөнгөөр шийдвэр гүйцэтгэлийг хангах ажиллагаа дуусна.

Нүүлгэн шилжүүлэх нь түрээслэгчийг өмчлөгчийн эзэмшлийн байрнаас гаргах тухай бөгөөд нүүлгэгчийн амьдралд чухал нөлөө үзүүлдэг журам бөгөөд ихэвчлэн уг ажиллагааг эхлүүлэхэд хатуу шаардлага тавьж, шүүхээр шийдвэрлэдэг.

Хураан авах (битүүмжлэх) нь гуравдагч этгээдийн мэдэлд байгаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг сайн дурын үндсэн дээр шүүхийн болон хуулийн дагуу хадгалуулах явдал юм. Шийдвэр гүйцэтгэгч нь хөрөнгийг зохих кастодианыг тодорхойлсон гуравдагч этгээдэд хадгалуулах үүрэгтэй.⁷⁴

⁷³ How to enforce a court decision, Spain https://e-justice.europa.eu/52/EN/how_to_enforce_a_court_decision?SPAIN&member=1

⁷⁴ European Union's Justice Programme (2014-2020), Civil enforcement in the EU: a comparative overview, <https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>

Испани улсын Иргэний процессын хуулийн 592.2-р зүйлд зааснаар хөрөнгийг хураан авахдаа дараах дарааллыг хэрэглэнэ. Үүнд:

1. Аливаа төрлийн мөнгө болон харилцах данс.
2. Шууд болон богино хугацаанд хэрэгжих зээл, эрх, албан ёсны хоёрдогч хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдахыг зөвшөөрсөн үнэт цаас, үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгсэл.
3. Үнэт эдлэл, урлагийн бүтээл.
4. Мөнгөн орлого, түүний гарал үүсэл, хуримтлагдсан эх үүсвэрээс үл хамааран.
5. Бүх төрлийн хүү, ашиг, орлого.
6. Хөдлөх эд хөрөнгө буюу мал, хувьцаа, үнэт цаас, нийтэд арилжаалагддаггүй, компанийн эзэмшилд байгаа хөрөнгө.
7. Үл хөдлөх хөрөнгө.
8. Цалин, тэтгэвэр, бие даасан мэргэжлийн болон арилжааны үйл ажиллагааны орлого.
9. Дунд болон урт хугацаанд хэрэгжих зээл, эрх, үнэт цаас.

Хураан авах ажиллагаанд төлбөр төлөгчийн бэлэн мөнгө эсвэл харилцах дансанд байгаа мөнгөн дүнг илүүд үздэг. Биет хөдлөх хөрөнгө (үнэт эдлэл, урлагийн бүтээлээс бусад)-ийг хураан авах нь жагсаалтын доогуур байх бөгөөд дараа нь үл хөдлөх хөрөнгө ордог. Банкны дансны мэдээллийг шууд өгдөггүй ч харилцах дансыг цахимаар хураах боломж бий. Энэ боломжийг Испанийн Шүүхийн ерөнхий зөвлөл болон Испанийн банк, зээлийн холбоодын хооронд байгуулсан гэрээгээр бий болгосон бөгөөд хадгаламж, шүүхийн шилжүүлгийн дансыг удирдаж буй гэрээлэгчийн ажиллуулдаг компьютерын програмаар дамжуулан хэрэгждэг.⁷⁵

Хэдийгээр шүүхийн захиргааны ажилтнууд шүүхийн шийдвэр болон бусад хувийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүргийг хэрэгжүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг ч Испанийн иргэний шийдвэр гүйцэтгэлийн хувьд арай өөр. Мэргэжлийн хуульчид болох прокурорууд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тодорхой үүрэг гүйцэтгэх ёстой бөгөөд энэ

⁷⁵ Wendy Kennett, *Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge*, 2021

үүргийг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд илүү их эрх мэдэлтэй оролцохыг эрмэлздэг.⁷⁶

Прокурор нь шүүх, талуудын өмгөөлөгчидтэй хамтран ажиллах бусад ажлыг, тухайлбал харилцаа холбооны үйл ажиллагаа, шүүн таслах ажиллагаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны процессын үе шат, хураан авсан эд хөрөнгийг албадан худалдах ажиллагааны хүрээнд мөн оролцож ажилладаг.

Испанийн иргэний процесс нь их төвөгтэй ба прокурорууд эдгээр харилцааг зохицуулах нарийн төвөгтэй байдлыг багасгах замаар шүүхэд тусалдаг. Шүүхүүд бүх өмгөөлөгчтэй (эсвэл шүүх бүрэлдэхүүнтэй биечлэн) харилцахын оронд илүү хязгаарлагдмал тооны эрх бүхий прокуроруудтай харилцах боломжтой. Энэ нь шүүхийн ажлын ачаалал, алдаа гаргах боломжийг багасгахын зэрэгцээ харилцааг процессын журмын дагуу явуулах баталгаа болж өгдөг.

Испанид прокурорууд шүүхийн ажилтнуудтай ижил төстэй шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үүрэг гүйцэтгэхийг удаан хугацаанд лоббидож ирсэн ба Иргэний процессын хуулийн 23 дугаар зүйл, 152-р зүйлийн 1-д зааснаар прокуроруудын эрх мэдлийг өргөтгөж, талууд болон гуравдагч этгээдтэй шууд харилцах боломжийг олгосон. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тодорхой дурдвал, төлбөр авагчийн нэрийн өмнөөс төлбөр төлөгчийн эд хөрөнгийг шалгах эрхийг прокуроруудад олгож, энэ талаар прокурортой хамтран ажиллах үүргийг "бүх хүн, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад" ногдуулдаг. Түүнчлэн Иргэний процессын хуулийн 641-р зүйлд өөрчлөлт оруулж, прокуроруудыг хөрөнгийн дуудлага худалдаагаар мэргэшсэн байгууллага гэж тодорхойлж, прокурорууд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нэмэлт үүрэг гүйцэтгэх болсон.

Испани улс цахим дуудлага худалдааг нэвтрүүлсэн нь Европын холбооны шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын дунд ихэд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд хураан авсан эд хөрөнгийн үнэ цэнийг хэрэгжүүлэх журамд чухал ахиц гарсан юм. Дуудлага худалдааны порталыг Испанийн Прокурорын ерөнхий зөвлөл болон төрийн захиргаа аль аль нь (улсын

⁷⁶ Мөн тэнд, 474 дэх тал

албан ёсны хэвлэлийг хариуцдаг төрийн агентлагаар дамжуулан) бий болгосон. Сүүлийн үед дуудлага худалдаа нь шүүхийн ажилтны хяналтын дор явагдаж байна.⁷⁷

(6) Швед улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Швед улсын ШШГГ-ын үйл ажиллагааны нэг онцлог нь өрийг барагдуулахын тулд авах арга хэмжээнүүдийг өөрсдөө шийддэг явдал юм. Ерөнхий төсөвт багтаан ямар хэргийг чухалчлах, ямар арга хэмжээ авахыг тодорхойлсон удирдамжтай ажиллана. Мөн шийдвэр гаргахдаа төлбөр төлөгч, төлбөр авагч, төрийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлсэн байдлаар ханддаг.⁷⁸

ШШГГ нь мөрдөн байцаалтын олон сонголттой байдаг. Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төрийн бусад байгууллагаас мэдээлэл авахыг зөвшөөрсөн тусгай заалт байхгүй ч анхны шийдвэр гаргах боломжийг олгодог мэдээллийн санд хандаж болдог. Шийдвэр гүйцэтгэх хүсэлтийг хариуцагчид мэдэгдсэний дараа ШШГГ нь төлбөр төлөгчийг бүртгэлд байгаа эсэхийг шалгана. Хэрэв байвал бол шинэ өрийг одоо байгаа мэдээлэл, үйл ажиллагааны хүрээнд нэмдэг. Харин шаардлагатай тохиолдолд иргэдийн талаарх мэдээллийг эхний ээлжинд татварын мэдээллийн сан, нийгмийн даатгалын мэдээллийн сан, замын хөдөлгөөний бүртгэлээс авдаг. Энэ мэдээлэл нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч, хөдөлмөрийн харилцаа, орлогын эх үүсвэрийг илчлэхэд хангалттай.⁷⁹

ШШГГ-ын эхний байр суурь нь төлбөр төлөгчтэй холбоо барьж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тэдэнд тайлбарлаж, нөхцөл байдлыг сайжруулахын тулд юу хийж болохыг олж мэдэх явдал юм. Мөн хувийн эрх зүйн хэргүүдэд ямар мөрдөн байцаалт явуулахыг өөрийн үзэмжээр тогтоодог. Хэрэв шийдвэр гүйцэтгэх арга хэмжээ үр дүнгүй гэж үзвэл тэд өргөдөл гаргагчид тайлбарлаж, цаашид ямар ч арга хэмжээ авахгүй. Гэсэн хэдий ч өргөдөл гаргагч энэ шийдвэрийг давж заалдаж болно. Нийтийн эрх зүйн хэрэг дээр төрийн өрийг барагдуулахтай холбоотой хууль тогтоомжийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх нь зүйтэй гэж үзвэл тухайн байгууллага хариуцагчийн эд хөрөнгө байгаа эсэхээс илүү санхүүгийн ерөнхий байдлыг судлах ёстой.

⁷⁷ Wendy Kennett, *Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge*, 2021, page 480

⁷⁸ Мөн тэнд

⁷⁹ Мөн тэнд

“Шинэчилсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам”-ын дагуу боломжит лавлагаануудыг тодорхойлж, лавлагаа авсан бүртгэлүүдэд эд хөрөнгө илрээгүй, төлбөр төлөгчтэй харилцах хаягаас өөр мэдээлэл байхгүй тохиолдолд төлбөр төлөгч нь хөрөнгөтэй байх магадлал багатай гэж дүгнэгдэж, шийдвэр гүйцэтгэх байгууллага тухайн хаягаар нь очих шаардлагагүй гэж үздэг. Энэ тохиолдолд мөрдөн байцаалтын стратеги боловсруулалгүйгээр шийдвэр гүйцэтгэлийн идэвхтэй ажиллагааг зогсоож, агентлаг үнэлгээний тайланг нэн даруй гаргадаг.

Мөн ШШГГ-т хөндлөнгийн хяналт тавих зохицуулалт бий. Шударга ёсны канцлер (Justitiekanslern) нь бүх төрийн байгууллагуудтай холбоотой хяналтын үүрэг гүйцэтгэдэг боловч нэлээд хязгаарлагдмал чадвартай байдаг. Канцлерын алба нь эрх бүхий байгууллагад үе үе шалгалт хийж, эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны улмаас хохирол учирсан гэх үндэслэлээр нөхөн олговор олгох тухай нэхэмжлэлийг хэлэлцдэг.⁸⁰

Хувь хүмүүсийн өрийг чөлөөлөх журмыг Өрийг нэгтгэх тухай хууль ((Skuldsaneringslag (2016:675))-аар зохицуулдаг. Эхлээд шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд мөрдөн шалгах ажиллагаа хийдэг. Бизнес эрхлэгчдэд тавигдах нэмэлт шаардлага байдаг ч хувь хүмүүс хуулийн дагуу өр төлбөрөө төлөх чадваргүй гэдгээ нотлох ёстой бөгөөд бүх нөхцөл байдлыг харгалзан үздэг (§7). Үндэслэлтэй байдлыг үнэлэхдээ өр үүссэн нөхцөл байдал, төлбөр төлөгч үүргээ биелүүлэхийн тулд гаргасан хүчин чармайлт, хэргийг шийдвэрлэхэд төлбөр төлөгчийн зохих оролцоог харгалзан үздэг (§9). Төлбөр төлөгчийн өгсөн мэдээллээс гадна ШШГГ нь өөрийн нэвтрэх боломжтой мэдээллийн сан дахь мэдээллийг шалгаж, төрийн байгууллагаас мэдээлэл авдаг (§15). Төлбөр авагчдаас мөн өрийн талаар мэдээлэл авдаг.

ШШГГ нь өр төлбөрөөс чөлөөлөгдөх өргөдлийг хүлээн авах эсэх болон төлбөрийн төлөвлөгөөний агуулгыг шийдвэрлэх эрхтэй. Ихэвчлэн төлбөрийг таван жилийн хугацаанд барагдуулдаг боловч ШШГГ энэ хугацааг дээд тал нь долоон жилээр богиносгож эсвэл сунгах эрхтэй. Мөн нөхцөл байдал өөрчлөгдөхөд төлөх төлбөрийн хэмжээг өөрчлөх боломжтой ба төлөх ёстой өрийн доод хэмжээ, хувь гэж байхгүй, засвар үйлчилгээ, баталгаатай нэхэмжлэл зэрэг зарим өрийг хасаж болно.

⁸⁰ Wendy Kennett, *Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge*, 2021, page 150-152

Шийдвэр гүйцэтгэх процессын төлбөр нь бага бөгөөд үргэлжлэх хугацаанаас хамаардаг. ШШГГ нь жилд 500 кроны (153,117 төгрөг) хураамж авдаг. Гэсэн хэдий ч Шведэд өр төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлтээс татгалзсан тохиолдол харьцангуй өндөр байна.

Сүүлийн жилүүдэд өр төлбөрөөс чөлөөлөх журмын хэрэглээ нэмэгдсэнээр өмнө нь насан туршдаа нэг л удаа хандах боломжтой байсан бол одоо дахин уг процесст хамрагдах боломжтой болсон. Шинэчлэлийн хүрээнд шаардлагатай төлбөрийг тооцохдоо нэг өрхийн хүүхдийн тоог илүүтэй харгалзан үзсэн янз бүрийн хялбаршуулсан тогтолцоог нэвтрүүлсэн.

VI. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

(1) Монгол Улс

Захиргааны байгууллагаас гаргасан захиргааны актыг албадан гүйцэтгэхийг захиргааны шийдвэр гүйцэтгэл гэж ойлгоно. Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн үндэслэл нь биелүүлэх ёстой хууль ёсны захиргааны акт байна.

Захиргааны шийдвэр гүйцэтгэхэд шаардах эрхийг нотолсон захиргааны акт гаргасан байх, үүрэг хүлээгчээс захиргааны актаар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй байх, шаардах эрх бүхий захиргааны шийдвэрийг үүрэг 14-өөс доошгүй хоногийн хугацаанд захиргааны шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэл хүргүүлсэн байх, шийдвэр биелүүлэх тухай зөвхөн бичгээр мэдэгдсэн байх, үүрэг биелүүлэх хугацааг заасан байх, албан ёсоор мэдэгдсэнээс хойш 14 хоногоос доошгүй хоногийн хугацаа өнгөрсөн байх нөхцөлүүдийг хангасан байх ёстой.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэгш эрх бүхий талууд оролцдог иргэний процесс, төрийн зүгээс санкц оногдуулдаг эрүүгийн процессоос ялгаатай. Захиргааны процессын эрх зүй нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар төрийн үйлдэл буюу захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны акт хуульд нийцэж буй эсэхийг хянадаг. Захиргааны хэргийн шүүхийн зорилго бол иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалахад чиглэдэг тул шийдвэр гүйцэтгэл нь энэ зорилгыг хангахад оршино. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч, төлбөр авагч, төлбөр төлөгчийн хооронд төлбөрийг биелүүлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны нийлбэр байдаг. Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хувьд нэг талд захирамжилсан шийдвэр гаргах эрхтэй захиргааны байгууллага, албан тушаалтан, нөгөө талд эрх нь хөндөгдсөн иргэн, хуулийн этгээд байдаг бөгөөд төлөөлүүлэн гүйцэтгэж болох эсвэл төлөөлөн гүйцэтгэж болохгүй онцлогтой байдаг.

Төлөөлүүлэн гүйцэтгэж болох ажиллагаа гэдэгт тухайлбал барилгыг буулгах ажиллагааг хэн нэгээр төлөөлүүлэн гүйцэтгүүлэх үйлдэл байдаг бол төлөөлөн гүйцэтгэж болохгүй ажиллагаа нь тухайн үйлдлийг гүйцэтгэж буй этгээдээс өөр хэн ч хийх боломжгүй үйлдлүүд хамаардаг. Тухайлбал: захиргааны зохих акт гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг зөвхөн тухайн захиргааны акт гаргах эрх бүхий захиргааны байгууллага албан тушаалтан л гаргах замаар биелүүлэхээс өөр хэн нэгэн уг захиргааны актыг гаргах эрхгүй тул төлөөлүүлэн гүйцэтгэх боломжгүй юм.⁸¹

(2) Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д Иргэний процессын хуулийн заалтууд нь Захиргааны харьяаллын тухай хууль (Administrative Jurisdiction Act)-д заасны дагуу энэ асуудалд холбогдох хэм хэмжээ бөгөөд энэ нь Германы захиргааны эрх зүйн онцгой шинж чанар юм. Нэхэмжлэгч нь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гаргах ёстой бөгөөд хууль тогтоомжид заасан шаардлага, тухайлбал шийдвэр гүйцэтгэх эрх байгаа эсэхийг шалгана. Хуулийн эрдэмтэд Захиргаанд зургаан сарын хугацааг олгох ёстой гэж үздэг, учир нь энэ нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэж болох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий дүрэм юм. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс авч болох хэд хэдэн арга хэмжээ багтсан бөгөөд хуулиар урьдчилан тогтоосон шийдвэр байхгүй ч шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хангахад хамгийн тохиромжтой арга хэмжээг сонгох эрх чөлөөтэй байдаг. Мөн шүүх хамгийн үр дүнтэй, хамгийн бага дарамт учруулах арга хэмжээг даалгах үүрэгтэй.⁸²

Германы Захиргааны шүүхийн тухай хуулийн 168-172 дугаар зүйлд шүүхийн тогтоол шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой тусгай заалтууд байна. ХБНГУ-ын Захиргааны шүүхийн процессын тухай хуулийн⁸³ 17 дугаар бүлгийн 167 дахь хэсэгт зааснаар (1) Энэхүү хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний процессын тухай хуулийн 8 дугаар дэвтэрт зааснаар гүйцэтгэлийг гүйцэтгэнэ. Гүйцэтгэх шүүх нь анхан шатны шүүх байна.

⁸¹ Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгохчадавхийг бэхжүүлэх” төсөл, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, УБ., 2021 он. <https://cdeaproject.files.wordpress.com/2016/12/2-zahirgaanii-hergiin-shuuihin-shiiddver-guitsetgeh-ajillagaa.pdf>

⁸² General reports of Congresses, The Execution of decisions of the administrative court, <http://safaat.lecture.ub.ac.id/files/2018/03/EXECUTION-OF-DECISIONS-OF-THE-ADMINISTRATIVE-COURT.pdf>

⁸³ Code of Administrative Court Procedure in the version of the promulgation of 19 March 1991 (Federal Law Gazette I page 686), most recently amended by Article 5, subsection 24 of the Act of 21 June 2019 (Federal Law Gazette I page 846) https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html

(2) Шүүхийн шийдвэр, гүйцэтгэлийг хүчингүй болгох, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөвхөн зардлын хувьд түр хугацаагаар гүйцэтгэж болно.

168 дугаар зүйл (1) Гүйцэтгэлийг дараах үндсэн дээр гүйцэтгэнэ

1. Шүүхийн эцсийн болон түр гүйцэтгэх тогтоол,
2. түр зуурын шүүхийн хориг,
3. Шүүхийн шийдвэр,
4. зардал тогтоох тушаал,
5. нийтийн эрх зүйн арбитрын шүүхийн шийдвэр.

(2) Гүйцэтгэхийн тулд холбогдох хүмүүст шүүхийн шийдвэрийн хуулбарыг баримт нотлох баримтгүйгээр, үндэслэлгүйгээр олгож болох бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрийг бүрэн гүйцэд танилцуулсантай дүйцнэ.

169(1) дугаар зүйлд Хэрэв шийдвэр гүйцэтгэлийг Холбоо (*federation*), газар, хотын корпорацийн холбоо, хотын корпорац эсвэл нийтийн эрх зүйн этгээд, байгууллага, сангийн хүсэлтээр гүйцэтгэх тохиолдолд Захиргааны гүйцэтгэлийн тухай хууль (*Verwaltungsvollstreckungsgesetz*)-ийн дагуу шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ. Уг хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэх эрх бүхий байгууллага нь анхан шатны шүүхийн даргалагч; тэрээр гүйцэтгэх ажиллагаа явуулах өөр байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн үйлчилгээг ашиглаж болно.

170 (1) Холбоо (*federation*), газар, хотын корпорацуудын холбоо, хотын корпорац, нийтийн эрх зүйн институци, сангийн эсрэг мөнгөн нэхэмжлэлийн шийдвэр гүйцэтгэх бол анхан шатны шүүх үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтээр гүйцэтгэнэ. Мөн шийдвэр гүйцэтгэлийн арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүсэлт гаргана. Хүсэлт гаргасан байгууллага нь түүнд хамаарах гүйцэтгэлийн заалтын дагуу шийдвэр гүйцэтгэлийг явуулах хүсэлтийг биелүүлэх үүрэгтэй. (2) Шүүх гүйцэтгэх захирамжийг гаргахаас өмнө эрх бүхий байгууллагад, эсхүл түүний эсрэг гүйцэтгэх ажиллагаа явуулахаар төлөвлөж буй нийтийн эрх зүйн корпорац, байгууллага, сангуудын хууль ёсны төлөөлөгчдөд шүүхээс тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхийг шаардсан шийдвэрийн тухай мэдэгдэнэ. Хугацаа нь нэг сараас илүүгүй байна. (3) Нийтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай, эсвэл нийтийн ашиг сонирхлын үүднээс худалдах боломжгүй зүйлийн хувьд шийдвэр гүйцэтгэлийг зөвшөөрөхгүй. Шүүх эрх бүхий хяналтын байгууллага, эсвэл холбооны эсвэл газрын дээд эрх бүхий байгууллагын эрх бүхий сайдыг сонссоны дараа эсэргүүцлийн шийдвэрийг гаргана.

172 дугаар зүйлд зааснаар Хэрэв 113 дугаар зүйлийн 1 дэх хэсэг⁸⁴, 123 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд эрх бүхий байгууллага шүүхийн шийдвэр, захирамжаар өөрт оногдсон үүргээ биелүүлээгүй бол анхан шатны шүүх эцсийн хугацааг тогтоох, сануулах, албан тушаалтанд арван мянган евро хүртэл албадлагын торгууль ногдуулах зэргийг тушаах хариу арга хэмжээ авч болно.

Тухайн шийдвэр эдгээр заалтад үл хамаарах бол хөндлөнгийн хуулийг хэрэглэх хэм хэмжээний талаар Захиргааны шүүхийн тухай хуулийн 167 дугаар зүйлд зааснаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой заалтуудыг баримталдаг ажээ.⁸⁵

(3) Бүгд Найрамдах Солонгос Улс

Бие даасан захиргааны шүүх байгууллагын хууль бус үйлдлээс иргэнд үүссэн хохирлыг барагдуулж, иргэний эрхийг сэргээх зорилгоор захиргааны шүүх ажиллагааг явуулна. Захиргааны шүүх ажиллагааны онцлог нь эрх зүйн асуудлаар маргаж байгаа талаасаа иргэний шүүх ажиллагаатай адил боловч ЗХХШтХ-д өөрөөр заагаагүй бол ИХШХШтХ-ийн дагуу шийдвэрлэхээр заасан нь онцлог юм. Өөрөөр хэлбэл иргэн, хуулийн этгээд болон захиргааны байгууллагын хооронд хийсэн “гэрээ”-ний хүрээнд үүссэн талуудын маргааныг шүүхийн байгууламжийн тухай хууль болон ИХШХШтХ-ийн дагуу шийдвэрлэдэг (ЗХХШтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2). Гэрээний бус захиргааны үйлчлэлээс үүссэн хэрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийхгүй. Учир нь захиргааны байгууллага өөрөө захиргааны акт үйлдэн тухайн актын хэрэгжилтийг хангахын тулд албадан гүйцэтгэх эрхтэй.

Захиргааны байгууллага иргэн хоёрын хооронд үүссэн маргааныг захиргааны шүүхээр шийдвэрлээд захиргааны акт хууль зөрчөөгүй гэж үзвэл захиргааны байгууллага тухайн актын хэрэгжилтийг хангахын тулд захиргааны албадлагын арга хэмжээг авна. Харин эсрэгээрээ захиргааны акт хууль зөрчсөн гэсэн шүүхийн шийдвэр гарвал захиргааны

⁸⁴ ХБНГУ-ын Захиргааны шүүхийн процессын тухай хууль 113(1). Захиргааны акт хууль бус бөгөөд нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн гэж үзвэл шүүх захиргааны акт болон аливаа шийдвэрийг хүчингүй болгоно. Захиргааны актыг аль хэдийн гүйцэтгэсэн бол шүүх хүсэлтийн дагуу мөн захиргааны байгууллага гүйцэтгэлийг хэрхэн хүчингүй болгохыг зааж өгч болно. Энэхүү мэдэгдлийг зөвхөн эрх бүхий байгууллага хийх боломжтой тохиолдолд л зөвшөөрөгдөнө.

https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html

⁸⁵ 1 Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. Доктор В.Дурнер. 243 дугаар тал (дам ишлэв)

байгууллага тухайн актыг хүчингүй болгон тухайн актын үйлчлэлээс иргэнд үүссэн хохирлыг иргэний шүүхээр шийдвэрлэж иргэний хохирлыг барагдуулна.

Захиргааны байгууллагын албадлага нь 5 төрөлтэй. Үүнд:

- *Төлөөлөн гүйцэтгэх*: Үүрэг хүлээгч захиргааны үйлчлэлтэй холбогдох ямарваа нэгэн үүргээ эс гүйцэтгэж хуульд заасан бусад албадлагын аргыг хэрэглэх боломжгүй тохиолдолд гуравдагч этгээд болох бусад хуулийн этгээдэд даалгаж болно. Гуравдагч этгээдийн ажлын хөлсийг үүрэг хүлээгч хариуцна. Захиргааны байгууллага нь “Орон нутгийн тухай хууль”-н 168 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн удирдах байгууллага, орон нутгийн байгууллагын удирдагч нь өөрийн харьяалан гүйцэтгэх ажлын хэсгийг орон нутгийн удирдах байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулан даалгаж болно. Уг гэрээг нийтэд ил тод зарлана.
- *Inposition of charges for compelling compliance*: Үүрэг хүлээгч захиргааны хуулийн дагуу үүргээ эс биелүүлэх тохиолдолд захиргааны байгууллага тодорхой хугацаа олгон, тухайн хугацаанд гүйцэтгэхгүй бол торгуулийн арга хэмээ авна.
- *Шууд албадлага*: Үүрэг хүлээгч захиргааны хуулийн дагуу үүргээ эс биелүүлэх тохиолдолд захиргааны байгууллага үүрэг хүлээгчийн биед болон эд хөрөнгөд халдаж тухай үүргийн гүйцэтгэлийг хангана.
- *Татварын албадлага* (compulsory collection): Үүрэг хүлээгч нь захиргааны холбогдолтой мөнгөн төлбөрийг төлөхгүй тохиолдолд үүрэг хүлээгчийн эд хөрөнгөд халдан үүргийн гүйцэтгэлийг хангана.
- *Immediate compulsion*: захиргааны үйл ажиллагаанд шууд нөлөөлж саад учруулсан дараах тохиолдолд захиргааны байгууллага ард иргэдийн бие, эд хөрөнгөд халдан захиргааны зорилгыг биелүүлнэ.
 - Захиргааны байгууллага урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан.
 - Тухайн үүргийн гүйцэтгэлийг захиргааны акт гаргаснаар биелүүлэх боломжгүй байсан.

Гэхдээ захиргааны байгууллага захиргааны шүүхийн шийдвэрийг эс гүйцэтгэх тохиолдолд ЗХХШтХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу захиргааны анхан шатны шүүх тодорхой хугацааны дотор шүүхийн шийдвэрийг эс гүйцэтгэвэл шүүхийн шийдвэр гүйцэтгээгүй хугацаанд үүссэн иргэний хохирлыг барагдуулах тогтоол гаргах бөгөөд БНСУ-д захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэж тусдаа бие даасан тогтолцоо байхгүй байна.

(4) Япон Улс

Гадаадын дийлэнх улсад захиргааны хэрэг хянан шийдвэрлэх асуудлыг захиргааны дагнасан шүүх хянан шийдвэрлэдэг бол Япон улсад Улсын дээд шүүх нь үндсэн хуультай холбогдох маргаан, захиргааны актыг хууль ёсны эсэхийг шалгах үүрэг бүхий шүүхийн байгууллага юм. Энэхүү шүүх нь иргэн, эрүүгийн бүх төрлийн хэргийг шүүн таслах, шийдвэрлэх эрхийг Үндсэн хуулиар олгосон байдаг. Гэхдээ захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Япон улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Administrative case litigation act) батлагдсанаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанаас онцлог ялгаатай болсон бөгөөд тодруулбал, захиргааны хэргийн мөн чанар, төрөл, маргаанд оролцогч талууд, олон төрлийн хэрэг үүсгэх нөхцөлийг, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, тус хуулиар нарийвчлан тодорхойлон зохицуулсан байдаг⁸⁶. Тодруулбал, Япон улс нь захиргааны хэрэг маргааныг 1962 оны 5-р сарын 16-ны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (Administrative case litigation act)-аар зохицуулдаг байна.⁸⁷ Тус хуульд зааснаар захиргааны хэргийн харьяаллыг тодорхойлохдоо захиргааны хэргийн хариуцагч эсхүл захиргааны байгууллага оршин байгаа байршлын шүүхэд гомдлыг гаргах эрхийг тус хуулийн 12-р зүйлийн 1 дэх заалтад заасан байна. Мөн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн харьяаллыг тодорхой хуульчлан заасан бөгөөд тус хуулийн 2-р зүйлийн 3-2 дэх хэсэгт Японд оршин суугаа хүний эсрэг гаргасан нэхэмжлэлийг тус газарт оршин байгаа шүүх, аль эсхүл хариуцагч нь корпорац, холбоо, сан, мөн бизнесийн байгууллага бол Үндсэн оффис байрлах шүүхэд харьяална хэмээн тус тус заасан байна⁸⁸.

Иймд иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд гаргасан гомдлыг ердийн шүүх иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэх журмыг баримтлан шийдвэрлэхийг хамааруулан үздэг байна. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд захиргааны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрт гомдол гаргах замаар явагддаг ба ихэнх тохиолдолд захиргааны байгууллагаас тогтоосон, татвар ногдуулах, сонгуультай холбоотой маргааныг эцэслэх замаар захиргааны байгууллагуудын захирамжийг хүчингүй болгохыг зэрэг иргэдийн гомдлууд захиргааны хэргийн дийлэнх хувийг эзэлдэг байна. Иймд тус хуулиас харвал Япон улсад зөвхөн захиргааны хэргийг

⁸⁶ Ushijima, H. (2008). Administrative law and judicialized governance in Japan. In *Administrative Law and Governance in Asia* (pp. 91-110). Routledge.

⁸⁷ Administrative case litigation act <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3781/en>

⁸⁸ Code of Civil Procedure Act (№109 of 1996)
https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2834#je_pt1ch1at3

хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий дагнасан Захиргааны хэргийн шүүх гэж байхгүй бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль мөн байхгүй онцлогтой байна.

Харин тус хуулиар захиргааны акт, захирамж зэрэг захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгох эрх бүхий байгууллага болох Нэгдсэн захиргааны агентлагууд (Incorporated Administrative Agencies) -ын эрх зүйн зохицуулалтыг Нэгдсэн захиргааны байгууллагуудын ерөнхий дүрмийн тухай хууль (Act on General Rules for Incorporated Administrative Agencies (Act No. 103 of 1999)- д тусгасан тус онцлогтой байна⁸⁹. Нэгдсэн захиргааны байгууллагуудын ерөнхий дүрмийн тухай хуулийн 2-р зүйлд зааснаар ““Incorporated Administrative Agencies” гэсэн нэр томъёо нь энэ хууль болон холбогдох хуулийн заалтын дагуу захиргааны гүйцэтгэлд ард иргэдийн амьдрал, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал зэрэг олон нийтийн үүднээс Төр өөрөө шууд аюулгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл явц, үйлчилгээг үр дүнтэй, үр дүнтэй явуулах дунд хугацааны зорилтын дагуу агентлаг хэлбэрээр байгуулагдсан корпорац, үндэсний судалгаа, хөгжлийн агентлаг, эсхүл үйл ажиллагаа эрхэлсэн агентлагийг хэлнэ.” хэмээн заасан байна.

Нэгдсэн захиргааны агентлаг (独立行政法人, Dokuritsu gyōsei hōjin эсвэл Dokugyo товчлол) нь өөрийн дүрэм, төсөв, албан тушаалтнуудын дагуу үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага юм. Эдгээр агентлагуудыг

1. Захиргааны хэрэг гүйцэтгэх агентлаг (Agency Engaged in Administrative Execution),
2. Үндэсний судалгаа, хөгжлийн агентлаг (National Research and Development Agency)
3. Дунд хугацааны зорилтын дагуу удирддаг агентлаг (Agency Managed under the Medium-term Objective) гэж чиг үүргээр нь гурав үндсэн хуваадаг байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Иргэний түр хамгааллын тухай хуульд заасан ямар ч түр захирамжийг захиргааны байгууллагын анхны захирамж, төрийн эрх мэдлийн хэрэгжилтийг бүрдүүлсэн аливаа үйлдэлд хамаарах эрхээ хамгаалах түр арга хэмжээ авах үед гаргаж болохгүй гэж заасан; хууль ёсны хэрэг гарсан бол шүүх хүсэлт гаргаснаар анхны захиргааны захирамжийн хүчин төгөлдөр болох, биелэлтийг түдгэлзүүлэх, эсхүл захиргааны байгууллага анхан шатны захирамж гаргах, эсхүл гаргахгүй байх түр захирамж гаргаж болно.

⁸⁹ Act on General Rules for Incorporated Administrative Agencies (Act No. 103 of 1999)
https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2754#je_ch2at7

(5) Испани улс

Захиргааны гомдол гаргахад процессын шаардлага нь гүйцэтгэх ажиллагаа эрхэлж буй байгууллагад ханддаг. Мөн ямар ч албан ёсны шаардлага байхгүй ба гомдлоо бичгээр гаргаж, нөхцөл байдлыг тодорхой тайлбарлаж, холбогдох талуудыг зөв тодорхойлсон байхад хангалттай байдаг.

Захиргааны байгууллага гомдлыг шалгах үүрэггүй. Гомдол гаргасан баримт, үйлдэл нь нотлогдохгүй ба/ эсвэл хууль зөрчсөн гэж үзэх боломжгүй тохиолдолд захиргааны байгууллага гомдлыг хэрэгсэхгүй болгоно.⁹⁰

Испанийн хууль тогтоомжид иргэний хохирлыг барагдуулах нэхэмжлэлийн хамтын зохицуулалтыг стандарт байдлаар заагаагүй (ангиллын ажиллагаа). Гэсэн хэдий ч Испанийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6-р зүйлд хор хөнөөлтэй үйл явдалд нэрвэгдсэн хэрэглэгчдийн бүлэг буюу хэрэглэгчид тухайн бүлэг нь тодорхой буюу шууд тодорхойлох боломжтой хүмүүсээс бүрдсэн тохиолдолд тухайн бүлэг нь олонх нь бүрдсэн тохиолдолд иргэний хэрэг үүсгэж болно гэж заасан байдаг. Нэмж дурдахад, Улсын Прокурорын газар болон Европын хамтын нийгэмлэгийн журмын дагуу хэрэглэгчдийн нийтлэг ашиг сонирхлыг хамгаалан хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагууд мөн иргэний хэрэг үүсгэж болно.

Испанийн Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх арга хэрэгсэл нь дараах 4-өөр хязгаарлагддаг. Үүнд: 1) хөрөнгийн хязгаарлалт, 2) туслах гүйцэтгэл, 3) албадлагын шийтгэл, 4) хүмүүсийг албадах аргууд байна. Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн арга хэрэгслийн төрлүүдийн хувьд зорилгоосоо хамааран зохицуулалт нь тодорхой төрлийн хэрэгжилтийг ашиглах хандлагатай байдаг. Жишээлбэл, мөнгөний нэхэмжлэлийг ихэвчлэн капиталыг хязгаарлах замаар хэрэгжүүлдэг; хийх үүргийг нэмэлт гүйцэтгэлээр буюу үе үе албадлагын алданги төлөх замаар гүйцэтгэж болно; Хувийн үүрэг хариуцлага нь бараг үргэлж хүмүүсийг албадахыг шаарддаг, гэх мэт. Гэсэн хэдий ч эрх зүйн янз бүрийн арга хэрэгслээр ижил үйлдлийг хэрэгжүүлэх боломжтой байх үед Захиргаа эрх чөлөө, өмчлөх үндсэн эрхийг тодорхой хэрэгжүүлэхийн тулд хамгийн хор хөнөөл багатай арга хэрэгслийг ашиглахыг илүүд үздэг.⁹¹

⁹⁰ Enforcement, Spain, <https://e-justice.europa.eu/37165/EN/enforcement?SPAIN&member=1> (Last update: 19/07/2022)

⁹¹ The administrative acts enforcement in the Spanish law. Bol. Mex. Der. Comp. [online]. 2016, vol.49, n.145. ISSN 2448-4873. https://www.scielo.org.mx/scielo.php?pid=S0041-86332016000100009&script=sci_abstract&tlng=en

VII. ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛЭЭС ЗАЙЛСХИЙХ ҮЙЛДЭЛ БОЛОН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

ХБНГУ-ын тухайд Иргэний процессын хуулийн 887 дугаар зүйлд зааснаар төлбөр төлөгч нь үүрэг гүйцэтгэгч гуравдагч этгээд үүргээ биелүүлээгүй бол төлбөр авагчийн хүсэлтийн дагуу анхан шатны шүүх хурлыг төлбөр төлөгчийн зардлаар шийдвэр гүйцэтгэх эрхийг олгох буюу анхан шатны шүүх хариуцагчийн зардлаар үйл ажиллагаа явуулах эрхийг төлбөр авагчид олгодог. Иймд шийдвэр гүйцэтгэх шүүхийн захирамж нь нэмэлт шүүх хуралдааны дараагаар гардаг. Уг шүүх хурлаар аливаа сонсгол хийдэггүй ч шүүх шийдвэр гаргахаас өмнө хариуцагчийг сонсох ёстой байдаг. (891 (2) дугаар зүйл). Энэ нь гуравдагч этгээдийн үйлдэлтэй холбоотой тул шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгох, эсхүл төлбөр авагч нь хариуцагчийн зардлаар гуравдагч этгээдээр үүрэг гүйцэтгүүлэх эрхтэй болно. Үүний зэрэгцээ тэрээр хариуцагчаас урьдчилгаа төлбөр хийхийг даалгах хүсэлт гаргаж болдог. (887 II дугаар зүйл).

Хариуцагч нь тухайн шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд төлбөр авагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг татан оролцуулж болно. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргасан шийдвэрийг сонсголгүйгээр шууд давж заалдах боломжтой. Шууд давж заалдах хүсэлтийг төлбөр төлөгч болон төлбөр авагчийн аль аль нь гаргах боломжтой.

Иргэний процессын тухай хуулийн 888 дугаар зүйлд шийдвэрийг гуравдагч этгээд биелүүлэх боломжгүй тохиолдлыг хуульчилж өгсөн ба гуравдагч этгээд үүргийг гүйцэтгэх боломжгүй, уг үйлдэл нь хариуцагчийн хүсэл зоригоос шууд хамааралтай бол төлбөр төлөгчөөс захиргааны торгууль төлөх, нөхөн төлөх боломжгүй бол албадан саатуулах арга хэмжээ авах эсэхийг анхан шатны шүүх хүсэлтийн дагуу хэргийг хянан шийдвэрлэнэ. Хувь хүний торгуулийн хэмжээ 25,000 еврогоос хэтрэхгүй байх ёстой.⁹²

Швед улсын тухайд төлбөр төлөгч нь хөрөнгө орлогын мэдүүлгээ өгөх үүрэгтэй ба биелүүлээгүй эсвэл шүүх хуралдаанд оролцоогүй тохиолдолд торгууль ногдуулдаг. Мөн ШШГГ нь мөрдөн байцаалтын зорилгоор эд хөрөнгө байгаа байр эсвэл бусад газарт нэвтрэх эрхтэй. Гуравдагч этгээдүүд, тэр дундаа банкууд ч мөн ШШГГ-т мэдээлэл өгөх үүрэгтэй. Зарчмын хувьд гуравдагч этгээд хүсэлт гаргаад шүүх хуралдаанд оролцоогүй тохиолдолд захиргааны торгууль ногдуулдаг. Онцгой тохиолдолд төлбөр төлөгч болон аливаа

⁹² The actors of enforcement, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-2-actors-enforcement-1>

гуравдагч этгээд мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд дээд тал нь гурван сар баривчлагдана.⁹³

VIII. ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо улс орон бүрт өөрөөр тогтсон байна. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь шүүх эрх мэдлийн нэг бүрэлдэхүүн хэдий ч Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа бие даасан агентлаг тул захиргааны загвартай байна. Судалсан орнуудаас ХБНГУ болон Швед улс мөн адил захиргааны загварт хамаарч байна. Харин БНСУ нь шүүхийн загвартай бол Япон, Испани улсууд нь шүүхийн ажилтны загвартай байна. Ижил загвараар хөгжиж байгаа хэдий ч улс орнуудын эрх зүйн түүхэн хөгжил, онцлогоос хамааран нарийвчилсан зохицуулалтууд өөр байна. Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хэн хэрэгжүүлж буйгаас шалтгаалан тэдгээрийн эрх, хэрэгжүүлэх арга хэмжээ харилцан адилгүй байна.

Судалсан орнуудад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй гол хууль, тогтоомж нь иргэний процессын хууль, Шүүхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд байх ба зарим орнуудад өөр нарийн зохицуулалт агуулсан хууль журмуудаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоог баталгаажуулан хуульчилсан байна.

ХБНГУ-ын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй бүрэлдэн хөгжиж, 200 гаруй жил болсон байх тул хууль, эрх зүйн хүрээнд олон нарийвчилсан зохицуулалтыг оруулсан байна. Иргэний эрх зүй, захиргааны эрх зүйн аль алинд Иргэний процессын хуульд заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх зохицуулалтыг хэрэглэдэг. Бусад улсуудын адил шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах объект мөнгөн хөрөнгө эсхүл үл хөдлөх хөрөнгө байхаас хамааран шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрлийг сонгодог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн захиргаанд хамаардаг хэдий ч төрөөс санхүүжилгүй, шүүхээс тусдаа байрлаж, өдөр тутмын үйл ажиллагааныхаа зардлыг өөрсдөө хариуцдаг буюу улсын хэмжээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн нэгдсэн алба байхгүй ч холбооны 16 муж шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийнхээ бие даасан зохион байгуулалтын бүтцийг боловсруулж, хэрэгжүүлдгээрээ онцлогтой байна.

⁹³ Wendy Kennett, *Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge*, 2021

Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацааг хамгийн боломжит хурдан хугацаанд хийж гүйцэтгэх зохицуулалттай ба үл хөдлөх хөрөнгийн хувьд энэ хугацаа бусад шийдвэр гүйцэтгэх ажиллагаануудаас урт байна. Орчин үед шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүртэл цахимжуулж, процессыг хөнгөвчилж, холбогдох арга хэмжээг хурдан шуурхай авах боломжийг бүрдүүлж байгаа нь Испани, Швед улсуудын жишгээр харагдаж байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай судалсан орнууд нь иргэний процессын хууль дахь зохицуулалтыг ашиглаж байна. Харин Япон улсын хувьд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоо нь нарийвчлан хуульчлагдаагүй байна. Учир нь Япон улсын шүүх нь Монгол улс шиг хэргийг дагнан харьяалан шийдвэрлэдэг төрөлжсөн шүүх гэж байхгүй бөгөөд анхан шатны шүүх, дүүргийн шүүх нь бүх төрлийн хэргийн харьяалан шийдвэрлэдэг нэгдмэл шүүхийн тогтолцоотой тул захиргааны хэргийн шүүх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай онцлог бүхий тогтолцоо байхгүй байгааг онцлон дурдах нь зүйтэй. Харин зөвхөн захиргааны хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр гарсан даруйд холбогдох төрийн байгууллагууд захиргааны акт, захирамжуудыг шууд хүчингүй болгох үүргийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиар шууд хүлээсэн байх бөгөөд энэ тохиолдолд захиргааны шийдвэр гүйцэтгэгчийн шаардлага байхгүй тул захиргааны шийдвэр гүйцэтгэгчийн оролцоогүйгээр хийгддэг онцлогтой байна.

Европын орнууд болох ХБНГУ, Испани, Швед улсуудад шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж болохгүй эд хөрөнгө, төлбөр төлөгчийн амьдралын баталгааг хангаж буй орлогын эх үүсвэр, хөрөнгийг хурааж авах, халдахгүй байх талаарх зохицуулалтыг хуулиар илүү нарийвчлан өргөн хүрээнд зааж өгсөн байна. Жишээ нь ХБНГУ-д төлбөр төлөгч, төлбөр авагч хоёулангийнх нь эрх ашгийг хамгаалсан зохицуулалтуудыг оруулсан байна.

IX. НОМ ЗҮЙ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2017.
<https://legalinfo.mn/mn/detail/12701>
2. Г.Агар-Эрдэнэ, Зарим орнуудад шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн болон нийгмийн баталгааг бүрдүүлсэн байдал.
<http://resource3.sodonvision.com/courtservice/file/2013/5/vyv25zucdca11en0d4clusfm/12.Shuuhiin%20shiidver%20quitsetgegchiin%20erh%20zuin%20batalgaa%20HEUK%20G.Agar-erdene.pdf>
3. Государственная и частная системы принудительного исполнения: сравнительный анализ и лучшие практики: сборник материалов 9-й Международной научно-практической конференции, 10-13 октября 2018 г., г. Сочи, Краснодарский край/ отв. Ред. Д.В.Аристов, В.А.Гуреев. М., 2019.
4. А.Лхагваа. Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2004.
5. Wendy Kennett, Civil Enforcement in a Comparative Perspective: A Public Management Challenge, 2021
6. How to enforce a court decision, Germany, https://e-justice.europa.eu/content_procedures_for_enforcing_a_judgment-52-de-en.do?member=1
7. All-Russian State University of Justice, State and private enforcement systems: Comparative analysis and the best practices, Walter Gietmann, Federal Director of the Union of Bailiffs of Germany, “The German bailiff system”, Moscow, 2019
8. Enforcement of Judgments Germany, <https://practiceguides.chambers.com/practice-guides/comparison/683/7154/11684-11686-11694-11701>
9. The actors of enforcement, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-2-actors-enforcement-1>
10. The Enforcement of a Title in Germany,
https://www.mmrecht.com/claim_collection/enforcement_en.php
11. All-Russian State University of Justice, State and private enforcement systems: Comparative analysis and the best practices, ANDREAS ZEDEL, High bailiff at the District Court of Eisenach/Thuringia, “The departmental responsibilities of the German bailiff - En transformation process from seizure and recovery to information gathering”, Moscow, 2019.

12. Civil enforcement in the EU: a comparative overview, Comparative Report,
<https://www.enforcementatlas.eu/wp-content/uploads/2021/03/EU-Enforcement-Atlas-Comparative-Report.pdf>
13. The prerequisites for execution, Germany, <http://www.europe-eje.eu/en/fiche-thematique/note-1-prerequisites-execution-1>
14. Litigation and enforcement in Germany: overview,
[https://content.next.westlaw.com/practical-law/document/I2ef128401ed511e38578f7ccc38dcbee/Litigation-and-enforcement-in-Germany-overview?viewType=FullText&ppcid=df4d45c30f1144d893ff704fab5d424d&originationContext=knowHow&transitionType=KnowHowItem&contextData=\(sc.Default\)&firstPage=true](https://content.next.westlaw.com/practical-law/document/I2ef128401ed511e38578f7ccc38dcbee/Litigation-and-enforcement-in-Germany-overview?viewType=FullText&ppcid=df4d45c30f1144d893ff704fab5d424d&originationContext=knowHow&transitionType=KnowHowItem&contextData=(sc.Default)&firstPage=true)
15. 법원행정처, 2021 사법연감, 617 면.
16. 허승, 유체동산의 가압집행에 있어 집행관이 부담하는 주의의무에 대한 검토,
한국민사집행법학회, 2018, 195 면.
17. Bennett, F. (1999). Civil Execution in Japan: the legal economics of perfect honesty. Nagoya University Law Review, 177.
18. https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3900/en#je_pt4ch2
19. Court Act (Act No. 59 of 1947
https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3900/en#je_pt4ch2
20. Civil Execution Act (Act No. 4 of 1979)
https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3483#je_ch1at2
21. Suk, K. H. (2018). Recognition and Enforcement of Judgments Between China, Japan and South Korea in the New Era: South Korean Law Perspective. Frontiers of Law in China, 13(2), 171–201. <https://doi.org/10.3868/s050-007-018-0013-7>
22. Shimomura, M. (2010). Civil Execution System and Insolvency System. Available at SSRN 1612704.
23. <https://practiceguides.chambers.com/practice-guides/enforcement-of-judgments-2021/japan/trends-and-developments>
24. General reports of Congresses, The Execution of decisions of the administrative court,
<http://safaat.lecture.ub.ac.id/files/2018/03/EXECUTION-OF-DECISIONS-OF-THE-ADMINISTRATIVE-COURT.pdf>

25. Code of Administrative Court Procedure in the version of the promulgation of 19 March 1991 (Federal Law Gazette I page 686), most recently amended by Article 5, subsection 24 of the Act of 21 June 2019 (Federal Law Gazette I page 846) https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html
26. ХБНГУ-ын Захиргааны шүүхийн процессын тухай хууль
https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html
27. Ushijima, H. (2008). Administrative law and judicialized governance in Japan. In Administrative Law and Governance in Asia (pp. 91-110). Routledge.
28. Administrative case litigation act
<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3781/en>
29. Code of Civil Procedure Act (№109 of 1996)
https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2834#je_pt1ch1at3
30. Act on General Rules for Incorporated Administrative Agencies (Act No. 103 of 1999)
https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2754#je_ch2at7
31. Enforcement, Spain, <https://e-justice.europa.eu/37165/EN/enforcement?SPAIN&member=1> (Last update: 19/07/2022)
32. The administrative acts enforcement in the Spanish law. Bol. Mex. Der. Comp. [online]. 2016, vol.49, n.145. ISSN 2448-4873. https://www.scielo.org.mx/scielo.php?pid=S0041-86332016000100009&script=sci_abstract&tlng=en